# НИЙГМИЙН ТУХАЙ МЭДЛЭГ

# 2009

## ХУВИЛБАР B

## НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

1. Нийгмийн хэв маягуудыг дурдахдаа хамааралгүй зүйл оруулсан бол аль нь вэ? (2 оноо)
   A. Анчин, түүгчдийн нийгэм
   B. Мал аж ахуйн нийгэм
   C. Газар тариалангийн нийгэм
   D. Гар урлалын нийгэм
   E. Бүгд хамааралтай
2. Тодорхой нэг хүний өвөрмөц авьяас чадвар, өөрт нь заяагдсан статусыг … гэнэ. (2 оноо)
   A. Төрөлх статус
   B. Заягдмал статус
   C. Хувь хүний статус
   D. Бие хүний статус
   E. Нуугдмал статус
3. Социал дэвшлийг шинэтгэлийн ба хувьсгалын хэмээн ангилан авч үздэг. Нийгмийн хувьсгалын шинж аль нь вэ? (2 оноо)
   A. Оршин буй социал тогтолцооныхоо үндсийг хөндсөн, нийгмийн амьдралын ихэнх хүрээг өөрчлөх үйл явц
   B. Оршин буй социал тогтолцооныхоо үндсийг хөндөлгүйгээр нийгмийн амьдралын аль нэг хүрээн дэх хэд хэдэн байнгын жигд тогтвортой өөрчлөлтийн үйл явц
   C. Нийгмийн хөгжлийн хурдац нь нийгэмд эерэг хандлага, үр дагавар авчрах үйл явц
   D. Нийгэм, түүхийн хурдац нь нийгэмд сөрөг үр дагавар авчрах үйл явц
   E. Нийгмийн улс төрийн амьдралд шинэтгэл хийх үйл явц
4. Нийгмийн институтыг үндсэн ба үндсэн бус гэж ангилдаг. Үндсэн институтын ангилалд аль нь хамаарах вэ? (2 оноо)
   A. Соёлын институт
   B. Оюун санааны институт
   C. Шашны институт
   D. Эрүүл мэндийн институт
   E. Институт
5. Хувь хүний шилжих хөдөлгөөний өөрчлөлтөнд аль хүчин зүйл нь нөлөөлөхгүй вэ? (2 оноо)
   A. Төрийн эргэлт, шинэчлэлт
   B. Мэргэжлээ дээшлүүлэх
   C. Боловсролын түвшингээ ахиулах
   D. Албан тушаал ахих
   E. Хичээл зүтгэл, чармайлт
6. АНУ болон ОХУ-д одоо хэр нь аж үйлдвэржилтийн өмнөх хэв шинжийн амьдралтай аж төрдөг овог, аймаг, муж байдаг нь нийгмийн хөгжлийг тайлбарлах дараах онол, хандлагын алинаар тайлбарлагдах вэ? (2 оноо)
   A. Түүхийн хурдцын хууль
   B. Шалтгаант чанарын хандлага
   C. Ард түмэн ба үндэстнүүд ижил биш хурдацтай хөгждөг хууль
   D. Мөргөлдөөний онол
   E. Тогтолцооны хандлага
7. “Мобиком” корпорацид менежер хийж байсан Т ажилдаа чадваржин улмаар салбар нэгжийн захирлаар томилогдов. Энэ нь шилжих хөдөлгөөний аль хэлбэрт хамаарах вэ? (2 оноо)
   A. Үе хоорондын шилжих хөдөлгөөн
   B. Босоо шилжих хөдөлгөөн
   C. Уруудах шилжих хөдөлгөөн
   D. Хэвтээ шилжих хөдөлгөөн
   E. Бүлгийн шилжих хөдөлгөөн
8. Уламжлалт нийгмүүдэд болон орчин үеийн ядуу буурай гуравдагч хэмээгддэг улс орнуудад ажиглагдаж буй давхраажлын хэлбэр аль нь вэ? (2 оноо)

A. B. C. D. E.



9. “Нийгэм” хэмээх ойлголтыг тайлбарлах янз бүрийн хандлагууд бий. Дараах үзэл хандлагууд, гол төлөөлөгчдийг зөв харгалзуулна уу. (4 оноо)

| | |
|---|---|
| 1. М.Вебер | a. Нийгэм гэдэг нь бусад хүмүүс болон үйл явдалд хандсан нийгмийн бүтээгдэхүүн болдог хүмүүсийн харилцан үйлчлэл юм |
| 2. Т.Парсонс | b. Холбогч эхлэлийн цэг нь хэм хэмжээ ба үнэт зүйлс байдаг хүмүүсийн хоорондын харилцааны түүхэн ёсоор хөгжигч цогц |

3. К.Маркс — c. Хөрөнгөтөн нийгмийн үндсэн ангиуд нь хөрөнгөтөн, хөлсний ажилчин бөгөөд энэхүү хоёр анги нь нийтлэг үнэт зүйлгүй, эсрэг тэсрэг анги тул байнга зөрчилдөж байдаг
4. Г.Спенсер — d. Хувь хүмүүсээр дамжин хэрэгждэг аливаа үзэл санаа, итгэл үнэмшил, мэдрэмжийн цогцолбор, зохиомж

A. 1a 2b 3d 4c　B. 1a 2b 3c 4d　C. 1d 2b 3c 4a
D. 1d 2c 3b 4a　E. 1c 2d 3b 4a

10. Гэр бүлийн хэв маягаас аль нь эхнэр, нөхрийн эрх тэгш байдлыг илэрхийлдэг вэ? (2 оноо)
A. Патриархаль　B. Эгалитар　C. Матриархаль
D. Полигами　E. Полиандри

11. Хүсэл зорилгоо хэрэгжүүлэх арга чадвар, боломжийг … гэнэ. (2 оноо)
A. Эд баялаг　B. Эрх мэдэл　C. Нэр хүнд
D. Орлого　E. Албан тушаал

12. Тусгай юмс үзэгдлүүд, баримтуудаас ерөнхий үндэслэл, дүгнэлт гаргах нь … юм. /Нөхнө үү/ (2 оноо)
A. Анкетын арга B. Анализ C. Синтез
D. Индукцийн арга E. Дедукцийн арга

13. Нийгмийн жижиг бүлгийн үндсэн шинжийг тодорхойлно уу. (2 оноо)
A. Гишүүд нь орон зайн хувьд ойр байдаг
B. Гишүүдийн зан байдлыг албан бусаар хянадаг
C. Бүлэгт сайн дурын үндсэн дээр элсдэг
D. A, C хариулт зөв
E. Дээрх бүгд

14. 1992 оны 1 сарын 13-ны өдөр батлагдсан Монгол улсын шинэ Үндсэн хуулийн онцлог шинжүүдийг дурдахдаа хамааралгүй зүйл оруулсан бол аль нь вэ? (2 оноо)
A. Манай улсын нэр өөрчлөгдсөн
B. Ерөнхийлөгч бүхий парламентын засаглалтай болсон
C. Хүний эрх, эрх чөлөөг тунхаглан баталгаажуулсан
D. Олон намын тогтолцоо бий болсон
E. Феодал, лам нарын улс төрийн эрхийг хассан байсныг өөрчилсөн

15. Улс төрийн хүрээний гол агуулгыг тодорхойлдог ойлголтуудад аль нь орохгүй вэ? (2 оноо)
A. Улс төрийн онол　B. Улс төрийн ухамсар　C. Улс төрийн бодлого
D. Улс төрийн сурах бичиг　E. Улс төрийн үнэт зүйлс

16. Засаглалыг Хууль тогтоох, Гүйцэтгэх, Шүүх гэж гурав ангилсан эрдэмтэн аль нь вэ? (2 оноо)
A. М.Вебер　B. Т.Парсонс　C. Д.Истон
D. Ш.Монтескье　E. В.Парето

17. Хүний эрх, эрх чөлөөг хамгаалахын төлөө эрх зүйт хуулийг дээдэлдэг төр ёсны мөн чанар буюу төр, иргэний нийгэм хоёр эрх зүйт хуулийн үндсэн дээр харьцангуй тэнцвэртэй орших арга загварыг … гэнэ. /Нөхнө үү/ (2 оноо)
A. Төрийн хэлбэр　B. Эрх зүйт төр　C. Социал төр
D. Төрийн дэглэм　E. Төрийн байгууламжийн хэлбэр

18. Төрийг эртний, дорно дахины, грек-ромын, дундад үеийн, шинэ үеийн хэмээн ангилсан нь төрийн хэв маягийн ангиллын алинд нь хамаарах вэ? (2 оноо)
A. Эртний ангилал　B. Марксист ангилал　C. Иргэншлийн хандлага
D. Түүхэн хөгжлийн ангилал　E. Орчин үеийн ангилал

19. Ардчилсан бус дэглэмийн гол шинж аль нь вэ? (2 оноо)
A. Өмчийн олон хэлбэр
B. Улс төрийн плюрализм
C. Улс төрийн болон иргэний соёлд төр тулгуурлах
D. Хүний эрхийг баталгаажуулахад төрийн үзэл суртлыг чиглүүлэх
E. Хүний эрх, эрх чөлөөг нэг үзэл сурталд захируулах

20. Намыг хэрхэн тодорхойлж болох вэ?
A. Намууд өөрийн гишүүн гэдгээр халхавчилж шударга ял шийтгэлээс бултуулдаг
B. Нам нь төрийн албан тушаалыг шан харамж маягаар хуваарилдаг
C. Нам нь төрийн институтэд үл итгэх байдлаар ханддаг
D. Сонгуулийн үр дүнд нэр дэвшигчийг төрийн байгууллагад суулгах чадвартай улс төрийн бүлэг
E. Улс төрийн шийдвэрийг дэмжсэн буюу эсэргүүцсэн ухуулга сурталчилгааны компанийг зохион байгуулдаг бүлэг

21. Монгол улс МЭӨ III зуунаас 1920-иод оны дунд үеийг хүртэл хаант засаглалтай байсан бол дараа нь Бүгд Найрамдах засаглалтай болж өөрчлөгджээ. Энэ нь төрийн хэлбэрийн хувьд аль бодомжид тохирох вэ? (2 оноо)
    - A. Улс үндэстэн төрийн ямар хэлбэртэй байх нь тэдний хүсэл зоригийн хэрэг
    - B. Төрийн хэлбэр нь тухайн улсын хувьд мөнхийн хөдөлгөөнгүй хэвшмэл зүйл
    - C. Төрт ёс нь дэлхий нийтийн уламжлалт тогтолцоог хадгална
    - D. Төрийн хэлбэр нь нийгэм хөгжих тусам шинэ агуулгаар баяжиж өөрчлөгдөж байдаг
    - E. Төрийн хэлбэр нь өөрийн уламжлалаа бусад улс үндэстэнд дэлгэрүүлдэг
22. Ямар шалтгааны улмаас хүмүүс хүний эрхийн төлөө, байгаль орчныг хамгаалахын төлөө, хээл хахууль, нийгмийн шударга бус байдлын эсрэг тэмцэж буй бүлгүүдэд нэгдэж ордог вэ? (2 оноо)
    - A. Материаллаг ашиг тусын тулд
    - B. Сэтгэл зүйн ашиг тусын тулд
    - C. Чөлөөт цагаа өнгөрүүлэхийн тулд
    - D. Хүсэл тэмүүллээ гүйцэлдүүлэхийн тулд
    - E. Нийгмийн байр сууриа өөрчлөх
23. Сонгуульд ялсан нам “Ямагт бүхнийг авах” зарчимд аль нь хамааралгүй вэ? (2 оноо)
    - A. Төрийн албан тушаалыг шан харамж маягаар хуваарилдаг
    - B. Нэг намын ноёрхлын үеийн монополи эрх мэдлийг санагалзсан явуургүй мөрөөдлөөс салж чадахгүй байдал
    - C. Парламентын намын нарийн чимхлүүр ажилд суралцах явдал
    - D. Ямар ч үнэ цэнээр хамаагүй эрх мэдлийн оройд гарахын төлөө зүтгэдэг явдал
    - E. Дээрх бүгд
24. Төрийн байгууллагууд эрх мэдлээ буруу ашиглахын эсрэг тэмцэх хамгийн сайн арга аль нь вэ? (2 оноо)
    - A. Захиргааны шүүхэд хандах
    - B. Ерөнхийлөгч хориг тавих
    - C. Үндсэн хуулийн цэцэд хандах
    - D. Хэвлэл мэдээллээр цацах
    - E. Дээд шүүхэд хандах
25. Монгол улсад 1990 онд болсон Улсын Бага Хурлын сонгуулийг ямар тогтолцоогоор явуулсан бэ? (2 оноо)
    - A. Мажоритар
    - B. Холимог
    - C. Пропорциональ
    - D. Аль аль нь зөв
    - E. Аль нь ч биш
26. Эрх зүйт төрийн үндсэн шинжийг аль нь тодорхойлохгүй вэ? (2 оноо)
    - A. Хууль дээдлэх ёс
    - B. Хүний эрхийг баталгаатай хангах
    - C. Шүүх зөвхөн хуульд захирагдах
    - D. Улс төр, эрх зүйн соёлтой байх
    - E. Нийгмийн тэгш ёсыг эмзэг бүлгийн хүрээнд хангах
27. Төрийн засаглалын хэлбэрүүдийг зөв тохируулна уу. (3 оноо)

| | |
|---|---|
| 1. Хаант засаглалын онцлог | a. Гадаад бодлогыг чиглүүлэн удирдах хариуцлагыг ерөнхийлөгч хүлээнэ |
| 2. Ерөнхийлөгчийн засаглалын онцлог | b. Ерөнхийлөгч төрийн тэргүүн, улс үндэстний тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын баталгаа, улс төрийн янз бүрийн хүчнүүдийн хоорондын маргааныг зохицуулагчийн үүргийг гүйцэтгэж байдаг |
| 3. Парламентын засаглалын онцлог | c. Үе залгамжлан эсвэл зарим тохиолдолд сонгогдсон нь засгийн эрхийг барина |

    - A. 1a 2b 3c
    - B. 1a 2c 3b
    - C. 1b 2c 3a
    - D. 1c 2b 3a
    - E. 1c 2a 3b
28. Ардчилсан нийгэмд ард түмэн засгийн эрхийг хэрхэн барих ёстой вэ? (2 оноо)
    - A. Ард түмэн шууд засаглах ёстой
    - B. Хууль зүйн хэм хэмжээ, шийдвэр боловсруулах замаар
    - C. Ард түмэн сэтгэл хөдлөлөө бүрэн ашиглах замаар
    - D. Оролцооны хэлбэрээр
    - E. Засгийн газрын бодлогыг тодорхойлох замаар
29. Зах зээл гэдгийг хэрхэн ойлгож болох вэ? (2 оноо)
    - A. Юуг, яаж, хэний төлөө гэсэн асуултын үүднээс нийгмийн эрэлт хэрэгцээг хангахад бүрэн чиглэсэн нэгдмэл цогц ойлголт
    - B. Бүтээгдэхүүн болон үйлчилгээ, үйл ажиллагааны үр дүнг солилцохын тулд үйлдвэрлэгч, хэрэглэгч нар үнэ, тоо хэмжээг тодорхойлж харилцан ажиллах хүрээ

C. Нийгмийн эрэлт хэрэгцээг хангахад бүрэн чиглэсэн тавaарын үйлдвэрлэл, хуваарилалт, арилжаа хэрэглээний нэгдмэл цогц
D. Хүн төрөлхтний олон үеийн амьдралын хөгжлөөр шалгарсан, нийгмийн үйлдвэрлэлийг өсгөн нэмэгдүүлэх, хүмүүсийн хэрэгцээг илүү сайн хангах үр дүнтэй хэрэгсэл
E. Бүх хариулт хамаарна

30. Хамгийн бага зардлаар бараа үйлчилгээг бий болгож, хурдан борлуулж чадсан нь ашигтай ажиллаж хүрээгээ тэлэх боломжтой болно. Хэрэв зардлаа нөхөөд ашигтай ажиллаж чадахгүй бол эцэстээ үйлдвэрлэл дампуурахад хүрнэ. Энэ нь өрсөлдөөний зах зээлд гүйцэтгэх үүргийн алинд нь хамаарах вэ? (2 оноо)
A. Баталгаажуулах хэрэгсэл
B. Бүтээмжийг урамшуулах
C. Шалгаруулах процесс
D. Өрсөлдөөн
E. Эрэлтийг бий болгох

31. Төрийн санхүүд аль нь хамааралгүй вэ? (2 оноо)
A. Улсын төсөв
B. Төсвийн гадуурх улсын сангууд
C. Улсын нийгмийн даатгал
D. Улсын эд хөрөнгийн даатгал
E. Хүн амын санхүүгийн орлого

32. Тодорхой хугацаанд өрөө төлөх тухай зээлдэгчийн хүлээсэн үүргийг гэрчилсэн өр төлөх баталгааг … гэнэ. (2 оноо)
A. Банкнот
B. Депозит мөнгө
C. Чек
D. Вексель
E. Электрон мөнгө

33. Аль нь чөлөөт зах зээлийн тогтолцооны үндсэн шинж вэ? (2 оноо)
A. Ашгийн хойноос хөөцөлдөх
B. Бүх шийдвэрийг төлөвлөгөөгөөр гаргана
C. Орлогын хуваарилалт нь зан заншилд тулгуурладаг
D. Эдийн засагт төрийн оролцоо өндөр байдаг
E. Дээрх бүгд

34. Дараах өгөгдлийн аль нь эд баялгийн үйлчилгээ вэ? (2 оноо)
A. Сүүний үйлдвэр
B. Хонины аж ахуй
C. Орон сууц барих
D. Гутлын үйлдвэрлэл
E. Нийтийн тээвэр

35. “Мөнгөний бодлого” гэдгийг хэрхэн тодорхойлж болох вэ? (2 оноо)
A. Мөнгөний нийлүүлэлт
B. Эдийн засаг дахь мөнгөний нийт тоонд болон тэдгээрийг тавьж олгох өртөгт нөлөөлөх
C. Гүйлгээнд мөнгийг гаргах, гүйлгээнд байгаа илүүдэл мөнгийг татан авах
D. Арилжааны банкны зээл олгох хэмжээг төв банкнаас зохицуулах үйл явц
E. Банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулах

36. Эдийн засгийн дараах зорилтуудаас аль нь тодорхой тоон хэмжүүртэй байдаг вэ? (2 оноо)
A. Эдийн засгийн баталгаа
B. Эдийн засгийн эрх чөлөө
C. Ажил эрхлэлтийн түвшин
D. Орлогын шударга хуваарилалт
E. Эдийн засгийн хууль

37. ЕБС-иа амжилттай төгссөнд баяр хүргэж ах нь Болдод 100.000 төгрөг өгчээ. Саяхан гар утсаа гээсэн тул утас авах бодолтой байсан боловч урьд нь авахыг хүсч байсан хөгжим нь хямдарсныг мэдээд түүнийг худалдан авав. Болдын тухайд алдагдсан боломжийн өртөг аль нь вэ? (2 оноо)
A. 100.000 төгрөг
B. Шинэ гар утас
C. Хөгжим
D. Гээгдүүлсэн гар утас
E. Алдагдсан боломжийн өртөг байхгүй

38. Эрэлт нэмэгдвэл ........ . (2 оноо)
A. Үнэ өснө, тоо хэмжээ өснө.
B. Үнэ буурна,тоо хэмжээ буурна.
C. Үнэ буурна, тоо хэмжээ өснө
D. Үнэ өснө, тоо хэмжээ буурна
E. Тэнцвэрт үнэ тогтоно.

39. Үйлдвэрлэгч шинэ бүтээгдэхүүн зохиолоо гэвэл түүнийг үйлдвэрлэх эрхийг тодорхой хугацаанд ганцаар эзэмших монополь эрхтэй байна. Энэ нь ямар замаар үүссэн монополь вэ? (2 оноо)
A. Засгийн газраас олгосон эрхийн улмаас үүссэн монополь
B. Нэгдэх замаар үүссэн монополь
C. Онцгой нөөцийг эзэмших замаар үүссэн монополь
D. Патентийн эрхийн улмаас үүссэн монополь
E. Төрөлхийн монополь

40. Ахиу орлогыг хэрхэн тодорхойлох вэ? (2 оноо)
A. Бүтээгдэхүүний үнэ, борлосон бүтээгдэхүүний хэмжээгээр илэрхийлэгдэнэ
B. Гарцын борлуулалт нэг нэгжээр өөрчлөгдөхөд нийт орлогод гарах өөрчлөлтөөр хэмжигдэнэ

C. Гарцын борлуулалтыг нийт орлогод харьцуулна
D. Борлогдсон бүтээгдэхүүний хэмжээг бүтээгдэхүүний үнэд харьцуулна
E. Нийт орлого, зарлагын зөрүү

41. Олон улсын худалдааны давуу талуудыг нэрлэхдээ хамааралгүй зүйл оруулсан бол аль нь вэ? (2 оноо)
A. Үндэсний нөөцийн хязгаарлагдмал байдлыг даван туулах боломж олгоно
B. Дотоодын зах зээлийн багтаамжийг тэлж, түүнийг олон улсын зах зээлтэй холбож өгнө
C. Нэмэлт орлого олох боломж бүрдэнэ
D. Хязгаарлагдмал үйлдвэрлэлийн хэмжээг өсгөж, борлуулалтыг нэмэгдүүлнэ
E. Хэрэглэгчид өндөр үнээр их тооны бараа үйлчилгээг олж авах

42. Зах зээлийн төрлүүдийг зөв харгалзуулна уу. (3 оноо)

| | |
|---|---|
| 1. Чөлөөт өрсөлдөөний зах зээл | a. Нэгэн төрлийн бүтээгдэхүүн олон, үнийг зах зээл тодорхойлно |
| 2. Олигополь | b. Нэгэн төрлийн бүтээгдэхүүн олон, үнийн манлайлах нөлөө байдаг |
| 3. Монопольт өрсөлдөөн | c. Ялгавартай бараа бүтээгдэхүүнтэй, үнийн нөлөөлөл хязгаарлагдмал |

A. 1a 2b 3c B. 1a 2c 3b C. 1b 2c 3a
D. 1b 2a 3c E. 1c 2a 3b

43. Аймгийн засаг даргын тамгын газарт хэрэглэж байсан хуучин машиныг дуудлагаар худалдав. Энэ тухай уг машиныг эзэмшиж байсан жолооч хожимдож мэдээд өөрөө давуу эрхээр худалдан авах ёстой хэмээн үзэж шүүхэд гомдол гаргажээ. Энд ямар асуудал үүссэн бэ? (2 оноо)
A. Өмч хувьчлал журмын дагуу явагдсан
B. Өмчтэй холбоотой хууль зүйн асуудал
C. Менежментийн үр дүнг харгалзан хувьчлах ёстой
D. Өмч хувьчлал болон түүнтэй холбоотой хууль зүйн асуудал
E. Жолооч өөрөө буруутай тул гомдлыг хэрэгсэхгүй

44. Далд эдийн засаг ямар үр дагавартай вэ? (2 оноо)
A. Дэлхийн эдийн засгийн хэмжээг бууруулах
B. Засгийн газрын бодлогыг гажуудуулахад хүргэх
C. Их хэмжээний татвар албан ёсны эдийн засагт тохогдоно
D. Албан ёсны эдийн засагт эргүүлэн оруулж буй ашиг нь түүний зардал хохирлоос давж магадгүй
E. Дээрх бүгд

45. Соёлын нэвчих үзэгдлийн сувгуудыг тоочихдоо хамаарахгүй зүйл оруулсан бол аль нь вэ? (2 оноо)
A. Цагаачлал B. Жуулчлал C. Худалдаа
D. Үйлдвэрлэл E. Дайн

46. Ёс суртахууны үндсэн ойлголт аль нь вэ? (2 оноо)
A. Сайхан, муухай B. Сайн, муу C. Үнэн, худал
D. Нүгэл, буян E. Дээрх бүгд

47. Сонгодог соёлын хэрэглэгчдэд хэн нь хамаарахгүй вэ?
A. Өндөр боловсрол бүхий шүүмжлэгчид B. Утга зохиол судлаачид
C. Музейн тайлбарлагчид D. Театрынхан
E. Дээрх бүгд хамаарна

48. Эзлэгдсэн орны ард түмэнд сүсэг бишрэлээ тулгахаас эхлээд зарим улс оронд “Америк аж төрөх ёс”, “Зөвлөлт аж төрөх ёс”-ыг хүчээр тулгах гэсэн оролдлогууд байсан нь аль үзлийн жишээ вэ? (2 оноо)
A. Этноцентризм B. Релятивизм C. Универсализм
D. Диффузи E. Дээрх бүгд

49. Алийг нь соёлын агуулах хэмээн нэрлэж болох вэ? (2 оноо)
A. Бичиг үсэг B. Хэм хэмжээ C. Уламжлал
D. Хэл E. Үнэт чанар

50. Соёлыг шаталсан байдлаар нь хэрхэн ангилдаг вэ? (2 оноо)
A. Элитийн, ардын, нийтийн, зонхилогч, дэд, сөрөг соёл
B. Элитийн, ардын, нийтийн соёл
C. Зонхилогч, дэд, сөрөг соёл
D. Үндэсний, мэргэжлийн, шашны соёл
E. Үндэсний, уламжлалт, орчин үеийн соёл

51. Өгөгдлийг зөв харгалзуулна уу. (4 оноо)

| | |
|---|---|
| 1. Соёлын албан бус хэм хэмжээ | a. Бүхий л соёлд нэгэн адил хамаардаг ерөнхий үнэт зүйлс |

2. Соёлын универсал шинж — b. Олон түмний санал сэтгэгдлээр дэмжигдэж байдаг сайн мууг тодорхойлогч ерөнхий дүрэм журам
3. Соёлын өвөрмөц шинж — c. Монгол улсын иргэн сонгох, сонгогдох эрхтэй
4. Албан ёсны хэм хэмжээ — d. Араб эмэгтэйчүүд нүүрээ халхалсан гивлүүр зүүдэг

A. 1a 2b 3c 4d B. 1b 2a 3d 4c C. 1d 2c 3b 4a
D. 1c 2a 3b 4d E. 1b 2d 3a 4c

52. Болд гэрээсээ гарч яваад хэтэвчтэй мөнгө олов. 100.000 төгрөг байснаас хагасыг нь үржээ. Орой иртэл ах нь хэтэвчээ гээсэн тухай ярьж байв. Болд мөнгийг нь үрсэн тул айгаад юу ч хэлсэнгүй. Болд ямар нэг хэм хэмжээ зөрчсөн үү? (2 оноо)
A. Эрхийн хэм хэмжээг зөрчсөн B. Шашны ёсыг гажуудуулсан
C. Ёс суртахууны хэм хэмжээг илүү зөрчсөн D. Улс төрийн хэмжээ зөрчсөн
E. Хэм хэмжээ зөрчөөгүй

53. Төрөөс бусад улстай харилцахад хэрэглэдэг янз бүрийн хэлбэрийн сурталчилгаа, мэдээлэл, соёлын бодлого зэрэг нь гадаад бодлогын хэрэгжилтэнд тавьсан зорилтуудыг биелүүлэхэд ашиглах хэрэгслийн алинд нь хамаарах вэ?
A. Мэдээлэл, суртал нэвтрүүлгийн B. Улс төрийн
C. Эдийн засгийн D. Цэргийн
E. Соёлын

54. Индонез, Тайланд, Малайз, Сингапур, Филиппин, Бруней зэрэг гишүүн орнтой бөгөөд бүс нутгийн хүрээнд энх тайван байдал, тогтвортой хөгжлийг хангаж бэхжүүлэх үйл ажиллагаа явуулдаг байгууллага аль нь вэ? (2 оноо)
A. АСЕАН B. ШХАБ C. АПЕК
D. Европын холбоо E. АСЕМ

55. Даяаршлын үйл явцад аль нь хамаарахгүй вэ? (2 оноо)
A. Анх эдийн засгийн хүрээнд хэрэглэгдэж байсан
B. Улс гүрнүүдийн хүрээнд хамтын ажиллагаа, хоорондын хамаарал улам бүр өргөн хүрээтэй, олон талтай, эргэлт буцалтгүй болж буй үйл явц
C. Олон хэмжээст, эргэлт буцалтгүй, дэлхий дахиныг нийтэд нь хамарсан, тодорхой туйлуудаас хамааралгүй үйл явц
D. Олон хэмжээст, эргэлт буцалтгүй, дэлхий дахиныг нийтэд нь хамарсан, тодорхой туйлуудаас хамаарах үйл явц
E. Улс орнуудын эдийн засгийн харилцан хамаарал нэмэгдэж, бүс нутагчлал өргөн тэлж байгаагаар илэрч байна

56. Монгол Улс эдийн засгийн гадаад харилцаандаа улс орныхоо хөгжилд ашиглах зорилгоор ямар асуудалд чухал ач холбогдол өгч ирсэн бэ? (2 оноо)
A. Түлш шатахуун, хүнсний зүйл B. Хүнсний зүйл, машин тоног төхөөрөмж
C. Хөрөнгө оруулалт, зээл тусламж D. Дотоодын хуримтлалаа нэмэгдүүлэх
E. Өнгөт металл, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн

57. Хүйтэн дайны үед дэлхийн бодлого 2 туйлт системээс бүрэлдэж байсан бол 1985 оноос социализм нуран унасан нь хэдэн туйлт системийг бий болгосон бэ? (2 оноо)
A. Олон туйлт систем B. Хоёр туйлт систем
C. Нэг туйлт систем D. Хараахан үүсээгүй
E. Хоёр ба олон туйлт системийн завсрын шинжтэй байсан

## ХОЁРДУГААР ХЭСЭГ

2.1. Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу. (5 оноо)
A. Мөнгөний бодлого — 1. Энэ бодлогын үед инфляци саарах боловч бодит хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл багасч, ажилгүйдэл өсөх магадлалтай
B. Хүүгийн бодлого — 2. Мөнгөн тэмдэгт, зоос гүйлгээнд гаргах онцгой эрх эдлэх үйл ажиллагаа
C. Мөнгөний хатуу бодлого — 3. Төв банк хүүгээ бууруулснаар бодит хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл нэмэгдэх боловч инфляци өсөх хандлагатай

D. Мөнгөний зөөлөн бодлого
E. Эмисс

4. Эдийн засаг дахь мөнгөний нийт тоонд болон хүүгийн хэмжээнд нөлөөлөх
5. Төв банкнаас арилжааны банкуудад олгох зээлийн хүү, хэмжээг мөнгөний ханш уналтын түвшинтэй хамааралтайгаар тогтоох үйл явц

2.2. Өгөгдлийг зөв харгалзуулна уу. (5 оноо)

A. Улс төрийн хүлээцтэй байдал
B. Иргэдийн оролцоо
C. Тэгш эрх
D. Чөлөөт шударга сонгууль
E. Хуульд захирагдах ёс

1. Бүх хүнийг ижил боломжтой байлгаж, арьс өнгө, шашин шүтлэг, үндэс угсаа, хүйсээр ялгаварлахгүй
2. Ард түмний олонх улс орныг удирдаж байхад цөөнхийн эрхийг хамгаалсан байх ёстой
3. Хүн бүр хуулийг сахина, зөрчвөл хариуцлага хүлээнэ
4. Иргэд өөрсдийнхөө талаар шийдвэр гаргахад идэвхтэй үйл ажиллагаа явуулах, бие даасан байр суурь баримтлах
5. Төр засагт өөрсдийгөө төлөөлөх албан тушаалтныг ажиллуулах, солих

2.3. Нийгмийн тухай үзэл, хандлагуудыг зөв харгалзуулна уу. (4 оноо)

A. Институтын хандлага
B. Шалтгаант чанарын хандлага
C. Функционализм
D. Мөргөлдөөний онол

1. Нийгэм нь бүхэллэг тогтолцоо болохынхоо хувьд эдийн засаг, нийгэм, улс төр, үзэл суртал зэрэг дэд тогтолцоонуудад хуваагддаг
2. Нийгмийн институтын хүрээн дэх социал амьдралыг хэрэгжүүлж буй хүмүүсийн цогцыг нийгэм гэнэ
3. Ангиудын хоорондын зөрчил нийгмийн үндэс язгуурт байдаг
4. Үүргээ алдах явдал үнэндээ тохиолддог бөгөөд энэ нь аяндаа засагдах буюу эцэс сүүлдээ нийгэмд бэхжин тогтож болно

## ХУВИЛБАР D

## НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

1. “Атомист” онолын хандлагаар бол нийгэм нь оршин амьдарч буй бие хүмүүс, тэдгээрийн хоорондын социал харилцааны цогц юм. “Атомист” онолын төлөөлөгч хэн бэ? (2 оноо)
   A. Г.Зиммель B. Э.Шилз C. К.Маркс D. Т.Парсонс E. Т.Мальтус
2. Социал дэвшлийг шинэтгэлийн ба хувьсгалын хэмээн ангилан авч үздэг . Аль нь нийгмийн шинэтгэлийн шинж вэ? (2 оноо)
   A. Оршин буй социал тогтолцооныхоо үндсийг хөндсөн, нийгмийн амьдралын ихэнх хүрээг өөрчлөх үйл явц
   B. Оршин буй социал тогтолцооныхоо үндсийг хөндөлгүйгээр нийгмийн амьдралын аль нэг хүрээн дэх хэд хэдэн байнгын жигд тогтвортой өөрчлөлтийн үйл явц
   C. Нийгмийн хөгжлийн хурдац нь нийгэмд эерэг хандлага, үр дагавар авчрах үйл явц
   D. Нийгэм түүхийн хурдац нь нийгэмд сөрөг үр дагавар авчрах үйл явц
   E. Нийгмийн улс төрийн амьдралд шинэтгэл хийх үйл явц
3. Үл мэдэх ба мэдэж болохгүй зүйлст хариулт өгөх, нийгмийн эв нэгдэл, зөвшилцөл тогтоох хэрэгцээг нийгмийн аль институт хангах вэ? (2 оноо)
   A. Гэр бүлийн институт
   B. Боловсролын институт
   C. Улс төрийн институт
   D. Эдийн засгийн институт
   E. Шашны институт
4. Гажуудал гэдэг ойлголтыг аль нь тодорхойлох вэ? (2 оноо)
   A. Хууль зөрчсөн аливаа үйлдэл
   B. Тогтворгүй зөрчилтэй болсон нийгмийн байдал
   C. Бүлэг буюу нийгмийн олонхийн хүлээн зөвшөөрсөн, байж байгаа хэм хэмжээ буюу хэм хэмжээний цогцтой үл нийцэх явдал
   D. Хэсэг бүлгийн хэм хэмжээний хазайлт
   E. Хүн нийгэмдээ зохицон амьдарч чадахгүйгээс үүссэн байдал

5. Аль нь уламжлалт нийгмийн шинж биш вэ? (2 оноо)
   A. Хөдөлмөрийн хуваарь, төрөл мэргэжил нь байгалийнх байдаг
   B. Хувь хүмүүсийн хооронд албан биш хувийн харилцаа давамгайлдаг
   C. Хүмүүсийн харилцаа нь ёс заншил, зан үйлд тулгуурладаг
   D. Удирдлагын болхи системтэй
   E. Удирдлагын нийлмэл систем бий болсон
6. 920-иод оноос өмнөх Монголын хүн амын давхраажил аль хэв маягт хамаарагдах вэ? (2 оноо)
   A. Боолчлол B. Каст C. Язгуур
   D. Анги E. Нээлттэй хэв маяг
7. Нийгэм түүхийг үзэх дараах онол сургаалын үзэл, гол төлөөлөгчдийг зөв харгалзуулаарай. (3 оноо)

| | |
|---|---|
| 1. Л.Н.Гумилев, Л.И.Мечников, Ш.Монтеське | a. Нийгмийг амьтны физиологийн бүтэцтэй адилтган интеграци, дифференциацийн зарчмаар тайлбарлах үзэл |
| 2. Ч.Дарвин, У.Беджгот, Л.Гумплович, Ж.Гобино | b. Нийгмийн хөгжилд хүн амын тоо, хүнс тэжээлийн нөөц чухал үүрэгтэй |
| 3. Т.Мальтус | c. Тухайн улс үндэстний хөгжилд газар зүйн орчин, уур амьсгал хөрс, усан мандал чухал үүрэгтэй |

   A. 1a 2b 3c B. 1b 2c 3a C. 1c 2b 3a D. 1c 2a 3b E. 1a 2c 3b
8. Хүй нэгдлийн үед ноёрхож байсан бэлгийн замбараагүй харьцааг ямар нэр томьёогоор илэрхийлдэг вэ? (2 оноо)
   A. Патриархаль B. Матриархаль C. Цус ойртолт
   D. Промискуитет E. Эгалитар
9. Багш хүн сурагчдад хангалттай мэдлэг , чадвар төлөвшүүлэх ёстой. Тухайн статусаас үүдэн бий болж, заавал биелүүлэх ёстой зан үйлийн хэм хэмжээний цогц бол … юм.
   A. Эрх B. Үүрэг C. Дүрэм
   D. Журам E. Хууль
10. Боловсролын бие хүнд нөлөөлөх эерэг нөлөөллийг дурдахдаа хамааралгүй зүйл оруулсан бол аль нь вэ? (2 оноо)
    A. Бие хүнд авьяас чадвараа хөгжүүлэх боломж олгож байдаг
    B. Тэгш байдлыг хангах хэрэгсэл
    C. Давхраажилтын дөрөв дэх хэмжүүр
    D. Хүрээлэн буй биет ертөнц, нийгмийн амьдрал, аж ахуйн үйл ажиллагааны тухай ерөнхий төсөөлөлтэй болох
    E. Бие хүнийг төлөвшүүлэх
11. Нийгмийг судлах энгийн олон арга байдаг. Нийгмийн үзэгдэл, үйл явцад судлаач өөрөө оролцох юмуу, оролцохгүйгээр мэдээлэл цуглуулах нь ямар арга вэ? (2 оноо)
    A. Анкетын арга B. Түүврийн арга C. Ажиглалтын арга
    D. Индукцийн арга E. Дедукцийн арга
12. Монголчууд мал аж ахуй эрхлэн нүүдэллэж амьдардаг тул газар тариалан эрхэлдэг өөр үндэстнийг бодвол хот суурингууд харьцангуй хожуу үүссэн. Энэ өгөгдлийг нийгмийн хөгжлийн аль хуулиар тайлбарлаж болох вэ? (2 оноо)
    A. Түүхийн хурдцын хууль
    B. Ард түмэн үндэстнүүд нь ижил хурдацтай хөгждөггүй тухай хууль
    C. Шалтгаант чанарын хандлага
    D. Мөргөлдөөний онол
    E. Тогтолцооны хандлага
13. Анхдагч нийгмийн бүлгүүдийн жишээнд аль нь орох вэ? (2 оноо)
    A. Оюутны нөхөрлөл B. Улс төрийн намын гишүүд C. Нэг нутгийнхан
    D. Нийгмийн нийтлэг E. Аль нь ч биш
14. БНМАУ 1940 онд Үндсэн хуулиа шинэчлэн найруулж баталсан байна. Энэ үндсэн хуулиар иргэдийн ямар ямар эрхийг баталгаажуулсан бэ? (2 оноо)
    A. Сонгох сонгогдох, хөдөлмөрлөх, өмчлөх, сурах
    B. Хөдөлмөрлөх, үнэ төлбөргүй амрах, сурах, нутаг бэлчээрийг ашиглах
    C. Хөдөлмөрлөх, эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо илэрхийлэх, сурах
    D. Нутаг бэлчээрийг ашиглах, үнэ төлбөргүй амрах, эдийн засгийн эрх
    E. Эвлэлдэн нэгдэх, үнэ төлбөргүй амрах, сурах, өмчлөх

15. Засаглалын субъект зорилгоо гүйцэлдүүлэхийн тулд объектод нөлөөлж буй арга хэрэгсэл аль нь вэ? (2 оноо)
    A. Засаглалын объект
    B. Засаглалын субъект
    C. Засаглалын нөөц
    D. Засаглалын механизм
    E. Засаглалын хэлбэр
16. Улс төрийн систем гэдэг онолын ойлголт хэдий үед бий болсон бэ? (2 оноо)
    A. XX зууны эхэн үе
    B. XX зууны дунд үе
    C. XX зууны сүүл үе
    D. XIX зууны сүүл үе
    E. Эрт үед
17. Хүмүүсийн амьдралын наад захын нөхцөл бололцоо, нийгмийн хамгааллаар хангахад илүү чиглэсэн бодлого явуулах зорилго бүхий төрийн хэв маягийг … гэнэ.
    A. Төрийн хэлбэр
    B. Эрх зүйт төр
    C. Социал төр
    D. Төрийн дэглэм
    E. Төрийн байгууламжийн хэлбэр
18. Платон, Аристотель нар Төрийг ангилах анхны оролдлого хийхдээ, ямар шалгуурыг үндэс болгосон бэ? (2 оноо)
    A. Эрх мэдлийг хэн хэрэгжүүлж буйг үндэс болгосон
    B. Өөрчлөлт хөгжилтийн онцлогийг үечлэн тодорхойлох ерөнхий хандлагад тулгуурласан
    C. Материаллаг үйлдвэрлэлийн хөгжлийн үе шатанд тулгуурласан
    D. Иргэншлийн онол, арга зүйг үндэслэн
    E. Төрөөс эрх мэдлээ хэрэгжүүлэх аргаар нь
19. Улс төрийн намын дотоод чиг үүрэгт аль нь хамаарах вэ? (2 оноо)
    A. Улс төрийн боловсон хүчнийг шилж сонгосны үндсэн дээр намын элит хэсэг ба улс төрийн лидерүүдийг бий болгох
    B. Иргэдийн улс төрийн идэвхийг сэргээн, аль болох улстөржүүлэх
    C. Намын хяналтын үүрэг
    D. Засгийн эрхийн төлөө тэмцэх
    E. Бусад намуудтай эвсэх боломжийг судлах
20. Бодит дэмжлэгт аль нь хамаарахгүй вэ? (2 оноо)
    A. Татвар төлөх
    B. Цэргийн алба хаах
    C. Эд материалын дэмжлэг үзүүлэх
    D. Төрийн бэлгэдлийг хүндэтгэн үзэх
    E. Сонгуульд саналаа өгөх
21. Монгол улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 5-д, “... Өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд мөнгөний тусламж авах эрхтэй” гэж заасан нь .... баталгаа юм. (2 оноо)
    A. Манай төр социал төрийн баримжаатай гэдгийн
    B. Манай төр эрх зүйт төрийн баримжаатай гэдгийн
    C. Хүмүүсийн байгалиас заяасан тэгш бус байдлыг засч залруулах
    D. Эдийн засгийн либерализм зах зээлийн зохицуулалтад давуу байдал олгодгийн
    E. Төр, иргэний нийгэм хоёр эрхзүйт хуулийн үндсэн дээр тэнцвэртэй орших
22. Сонгууль жинхэнэ утгаараа чөлөөт, шударга явагдах гол нөхцөл аль нь байж болох вэ? (2 оноо)
    A. Чөлөөт байдлыг хангах
    B. Нийгмийг ардчилах, улсаа удирдахад оролцох эрхийг хэрэгжүүлэх
    C. Төрийн үйл хэрэгт оролцох эрх
    D. Сонгууль өөрийн утгаараа ардчилал биш
    E. Хүний үндсэн эрхийг сахин хангаж, хүний эрхийн олон улсын стандартад нийцсэн байх
23. Засаглалын легитим шинжийг хэрхэн ойлгож болох вэ? (2 оноо)
    A. Хүчирхийлэлд тулгуурласан засаглал
    B. Иргэд эрх баригчдын захирах эрхийг зүй ёсны хэмээн хүлээн зөвшөөрөх
    C. Улс төрийн хошуучлалын нөлөөлөл
    D. Засгийн газар огцрох
    E. Засаглалын ялан дийлэх чадвар
24. Монгол улсын үндсэн хуулийн 20-р зүйлд, “… хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү УИХ-д хадгална” гэсэн нь .......... илэрхийлнэ. (2 оноо)
    A. Улс төрийн засаглалыг
    B. Улс төрийн дэглэмийг
    C. Нийтлэг эрх ашгийг
    D. Төрийн удирдлагын хэлбэрийг
    E. Төрийн бүрэн эрхийг

25. Сонгуулийн сурталчилгааг хэдийд зогсооно гэж заасан байдаг вэ? (2 оноо)
    A. Санал авах өдөр
    B. Санал хураахаас 24 цагийн өмнө
    C. Санал хураахаас 36 цагийн өмнө
    D. Санал хураахаас 48 цагийн өмнө
    E. Санал хураахаас 72 цагийн өмнө
26. Эрх зүйт болон социал төрийн зарчим, үзэл санаа өөр өөр ч адил тал бас бий. Аль өгөгдөл нь адил талыг илэрхийлэх вэ? (2 оноо)
    A. Хоёулаа хувь хүний сайн сайхан байдлыг хангах зорилгод үйлчилнэ
    B. Аль аль нь ардчилсан төрийн тогтолцооны хэв маяг
    C. Онолын үндэс нь социал демократ
    D. Дээрх бүгд адил талыг илэрхийлнэ
    E. Зөвхөн A, B нь адил талыг илэрхийлнэ
27. Төрийн чиг үүргийг зөв харгалзуулаарай. (3 оноо)
    1. Төрийн чиг үүрэг
    2. Төрийн дотоод чиг үүрэг
    3. Төрийн гадаад чиг үүрэг

    a. Нийгмийн амьдралын хүрээнд төрөөс заавал гүйцэтгэх ёстой эрх зүйн болон зохион байгуулалтын үйл ажиллагааны үндсэн чиглэл
    b. Улс орноо батлан хамгаалах
    c. Төрийн болон нийгмийн аюулгүй байдлыг хангах

    A. 1a 2c 3b  B. 1c 2a 3b  C. 1c 2b 3a  D. 1a 2b 3c  E. 1b 2a 3c
28. Улс төрийн эрх мэдлийг хэрэгжүүлж буй хүмүүс нь эрх мэдлээ буруу ашиглахад ямагт бэлэн байдаг. Тэгвэл эрх мэдлээ буруу ашиглаж буй үйлдэл аль нь байж болох вэ? (2 оноо)
    A. Засгийн эрх баригчид эрх мэдлээ өөрсдийн эрх ашгийн төлөө ашиглах
    B. Өөрсдийн эрх ашгийг хамгаалсан хууль батлуулах
    C. Хүмүүсийн нийгмийн ашиг сонирхлыг умартах
    D. Нийгмийн баялгийг эзэмших санаархал нь өндөр байх явдал
    E. Дээрх бүгд зөв
29. А.Смитийн “Үл үзэгдэгч гар” хэмээх томьёололд аль нь хамаарах вэ? (2 оноо)
    A. Далд эдийн засаг
    B. Төрөөс эдийн засгийг зохицуулах үйл явц
    C. Зах зээлд гүйцэтгэх өрсөлдөөний чиг үүрэг
    D. Зах зээлийн үндсэн шинж
    E. Зах зээлийн давуу тал
30. Хүний хөгжлийн индекс юугаар тодорхойлогдох вэ? (2 оноо)
    A. Эрүүл энх удаан амьдрал, мэдлэг, амьжиргааны түвшний үзүүлэлтүүд
    B. Эрүүл энх, урт удаан амьдрал, боловсрол, 1 хүнд ноогдох ҮНБ-ий хэмжээ
    C. Наслалт, мэдлэг, 1 хүнд ноогдох ҮНБ
    D. Амьжиргааны түвшний үзүүлэлтүүдийн нэгдсэн индекс
    E. Аль нь ч биш
31. Хэрэглээний нийт зардалд хүнс тэжээлийн эзлэх хувийн жингийн хэмжээ буурах тутам гэр бүл ядуурахыг илэрхийлэх үзүүлэлтийг … гэнэ. (2 оноо)
    A. Нэн ядуурал
    B. Харьцангуй ядуурал
    C. Үнэлгээний ядуурал
    D. Хэрэгцээний ядуурал
    E. Хүнс тэжээлийн ядуурал
32. Бүрэн ажил эрхлэлт гэж юу вэ?
    A. Ажилгүйдэл хэвийн түвшинд байхыг хэлнэ
    B. Ажилгүйдэл ердийн түвшинд байхыг хэлнэ
    C. Ажлын чадвартай хүмүүс ажлаар бүрэн хангагдсан байдлыг
    D. Ажилгүйдэл байхгүй үеийг
    E. Ажилгүйдлийн түвшин 1-3 хувьтай байх үеийг
33. Уламжлалт эдийн засгийн тогтолцооны шинжид аль нь орохгүй вэ? (2 оноо)
    A. Шашин анхдагч байдалтай
    B. Техникийн дэвшил, хөрөнгө оруулалт хийх явдал хязгаарлагдмал
    C. Үйлдвэрийн газар нь улсын даалгавар биелүүлэх гол үүрэгтэй
    D. Эдийн засагт хувь хүний үүрэг оролцоо ихтэй
    E. Нийгэм эдийн засгийн зогсонги байдал ноёлдог
34. Санхүүгийн банкны үүрэг аль нь вэ? (2 оноо)
    A. Эдийн засаг дахь мөнгөний хэмжээг зохицуулах
    B. Мөнгөний тогтворт байдлыг хангах
    C. Хөрөнгө оруулагч болон компаниудаас их хэмжээний мөнгөн хадгаламж хүлээн авах
    D. Мөнгөн хадгаламж хүлээж авах, зээллэг өгөх, олон улсын худалдаа арилжааг санхүүжүүлэх
    E. Дээрх бүгд зөв

35. Төрийн бус байгууллага, сангийн өмч гэдэгт алийг нь хамааруулан ойлгож болох вэ? (2 оноо)
    A. Гишүүд дэмжигчдийн татвар, хандив
    B. Дүрэмд нийцсэн үйл ажиллагааныхаа үр дүнд олсон орлого
    C. Буян үйлдэх зүйл, барилга, шүтээн
    D. Археологи, палеонтологийн олдвор
    E. Зөвхөн A ба B хариулт зөв
36. Эдийн засгийн шинжлэх ухааны судлах зүйлд хамаарахгүй ойлголт аль нь вэ?
    A. Үйлдвэрлэлийн үнэ
    B. Үйлдвэрлэлийн өсөлтийг хангах
    C. Үйлдвэрүүдийн өрсөлдөөн
    D. Үйлдвэрлэлийн технологи
    E. Үйлдвэрийн осол
37. Архангай аймгийн Батцэнгэл сумын ургамал, ан амьтны нөөцийг судалжээ. Энэ нь өмчийн аль хэлбэрт хамаарах вэ? (2 оноо)
    A. Төрийн өөрийн өмч
    B. Төрийн нийтийн зориулалттай өмч
    C. Орон нутгийн өмч
    D. Сангийн өмч
    E. Холимог өмч
38. Эрэлт буурвал ...... . (2 оноо)
    A. Үнэ өснө, тоо хэмжээ өснө
    B. Үнэ буурна,тоо хэмжээ буурна
    C. Үнэ буурна, тоо хэмжээ өснө
    D. Үнэ өснө, тоо хэмжээ буурна
    E. Тэнцвэрт үнэ тогтоно
39. Монголд бараа, үйлчилгээний үнийг чөлөөлөх анхны оролдлого хэзээ, хэрхэн хийгдсэн бэ? (2 оноо)
    A. 1991 оны 1-р сард Д.Бямбасүрэнгийн засгийн газрын тогтоолоор
    B. 1993 оны 5-р сард П.Жасрайн засгийн газрын шийдвэрээр
    C. 1996 оны намар М.Энхсайханы засгийн газрын шийдвэрээр
    D. 1991 онд УИХ-ын намрын чуулганаар
    E. 1994 онд УИХ-ын намрын чуулганаар
40. Хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэхийн тулд хэрхвэл зохистой вэ? (2 оноо)
    A. Нэгж хугацаанд үйлдвэрлэх бүтээгдэхүүний тоог нэмэгдүүлэх
    B. Хүмүүсийг олноор ажиллуулах
    C. Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх хугацааг богиносгох
    D. Үйлдвэрлэлийнхээ хүрээг тэлэх
    E. A ба C хариулт зөв
41. Өмч нь эдийн засгийн болоод хууль зүйн ойлголт юм. Доорх өгөгдлөөс аль нь хууль зүйн талыг илэрхийлэх вэ? (2 оноо)
    A. Ашиглалт
    B. Субъектийн халамж
    C. Үр ашгийг нэмэгдүүлэх
    D. Удирдах арга барил
    E. Бүгд буруу
42. Дараах ухагдахуунуудыг өгөгдөлтэй зөв харгалзуулаарай. (3 оноо)

| | |
|---|---|
| 1. Хөдөлмөрийн зах зээлийн үүрэг | a. Орлогын боломж, хөдөлмөрийн эрэлт, нийлүүлэлтийг зохицуулах |
| 2. Ядуурлын үр дагавар | b. “Оукены хууль” харуулдаг |
| 3. Ажилгүйдлийн үр дагавар | c. “Ядуурал - Өлсгөлөн - Өвчин” гэсэн гинжин холбоог үүсгэдэг |

    A. 1a 2b 3c    B. 1a 2c 3b    C. 1c 2b 3a    D.1c 2a 3b    E. 1b 2c 3a
43. Бат, Туяа нар гадаадад ажиллахаар явахдаа төрсөн дүү Болдод өөрсдийн өмчийн орон сууцыг түр эзэмшүүлжээ. Буцаж ирэхэд нь Болд хамтран эзэмшигч биш атлаа байрыг нь худалдаад гадаад явчихсан байв. Энд ямар асуудал үүссэн бэ?
    A. Өмчийг үрэгдүүлэх үйл ажиллагаа
    B. Өмч хувьчлалын асуудал
    C. Өмчтэй холбоотой хууль зүйн асуудал
    D. Өмчийг хамгаалах асуудал
    E. Асуудал үүсэхгүй
44. Татвар ноогдуулалт нь сангийн, зохицуулагч гэсэн хоёр үндсэн чиг үүрэгтэй. Зохицуулах чиг үүргийг урьтал болговол ямар үр дагаварт хүрч болох вэ? (2 оноо)
    A. Аж ахуй нэгжүүдийг дампууруулах
    B. Барааны хэрэглээг хязгаарлах
    C. Импортыг хязгаарлах
    D. Бизнес эрхлэгчдийн урмыг хугалахад хүргэх
    E. Төсвийн хямралд хүргэх
45. Сонгодог хөгжим соёлын аль хэлбэрт багтах вэ? (2 оноо)
    A. Нийтийн соёл
    B. Ардын соёл
    C. Элитийн соёл
    D. Дэд соёл
    E. Сөрөг соёл

46. Шашны нийгмийн үүргийг дурдахдаа илүүц зүйл оруулсан бол аль нь вэ? (2 оноо)
    A. Үнэт зүйлийн үүрэг
    B. Зохицуулах болон хэм хэмжээний үүрэг
    C. Хүмүүсийг нэгтгэх, туслалцаа үзүүлэх үүрэг
    D. Ертөнцийг үзэх үзлийн үүрэг
    E. Амьдралын баталгааг хангах үүрэг
47. Соёлыг шаталсан байдлын хүрээнд элитийн, ардын, нийтийн, зонхилогч, дэд, сөрөг соёл хэмээн ангилсан нь соёлын аль ангилалд хамаарах вэ? (2 оноо)
    A. Соёлын босоо чиглэл дэх ангилал
    B. Соёлын хэвтээ чиглэл дэх ангилал
    C. Соёлын хэлбэрийн ангилал
    D. Соёл судлалын ангилал
    E. Соёлын олон шатлалт ангилал
48. Сөрөг соёл нь … (2 оноо)
    A. Мэргэжлийн аль нэг бүлэгт хуваагдсан нийтлэг зан төрхийн бэлгэ тэмдэг, үнэт зүйлс, хэм хэмжээ бүхий соёл
    B. Зонхилох соёлын үндсэн талуудад зөрчилдсөн хэм хэмжээ, үнэт зүйл бүхий соёл
    C. Нийт хүн төрөлхтний соёлын нэг хэсэг болохын зэрэгцээ өөрийн гэсэн өвөрмөц шинжүүдтэй соёл
    D. Тухайн улс орон дахь хүмүүсийн нийтлэг итгэл үнэмшил, бэлгэдэл, зан үйлийн хэв загвар, үнэт зүйл, хэм хэмжээг тодорхойлж байдаг соёл
    E. Дээрх бүгд
49. Аль нь “Бэлгэ тэмдэг” хэмээх ухагдахууныг илэрхийлэх вэ? (2 оноо)
    A. Бэлгэ тэмдэг бол бусад зүйлс, үйлдэл, үйл явц, субъектив дүрийг тэмдэглэхэд хэрэглэгддэг материаллаг бөгөөд мэдэрч хүртэгдэх зүйл, үйл явц
    B. Бэлгэ тэмдэг бол нийгэм, нийгмийн бүлгийн гишүүдийн хувьд бүх нийтээр хүлээн зөвшөөрч нэг объект, үйлдлээр нөгөөгийнхөө утга учрыг илтгэх, илэрхийлэл үйлдэл, объект юм
    C. Бэлгэ тэмдэг нь тухайн зүйлийнхээ утгыг дамжуулдаг код юм
    D. Бэлгэ тэмдэг бол дүр төрх эсвэл дуу авиа байдаг бөгөөд утга илэрхийлдэг, эсвэл утгыг бий болгодог
    E. Дээрх бүгд
50. Алдарт аялагч Марко Полотой цуг явсан хятад тогооч Италид шпагеттийн жорыг авчирсан ба хожим нь Италийн цагаачид Америкт дэлгэрүүлжээ. Энэ алинаар нь тайлбарлагдах вэ? (2 оноо)
    A. Соёлын өөрчлөлтийн эх үүсвэр
    B. Соёлын диффузи
    C. Соёлын олон талт байдал
    D. Соёлын универсал
    E. Этноцентризм
51. Өгөгдлийг зөв харгалзуулаарай. (4 оноо)

| | |
|---|---|
| 1. Зуршил | a. Монголчууд цагаан сараар ахмад хүний тохойг өргөн золгодог |
| 2. Зан заншил | b. Алимаа орой 18 цагаас хойш махан хоол огт иддэггүй |
| 3. Хэм хэмжээ | c. Баяр бага хүүгийнхээ даахийг үргээж даага уралдууллаа |
| 4. Зан үйл | d. Бусдад нэр хоч өгч, хулгай дээрэм хийж болохгүй. |

    A. 1a 2b 3c 4d
    B. 1b 2a 3d 4c
    C. 1b 2a 3c 4d
    D. 1a 2d 3c 4b
    E. 1a 2c 3d 4b
52. Дараах үзэгдлүүдээс аль нь нийгэмд илүү хор уршиг авчрах вэ? (2 оноо)
    A. Хулгай, дээрэм тонуул
    B. Садар самуун явдал
    C. Нийтийг хамарсан архидан согтуурах явдал
    D. Тамхийг өргөн хэрэглэх
    E. Этгээд гаж хувцаслалт
53. Уламжлалт хэлбэрээс эхлэн дээд түвшний дипломат харилцаа, хэлэлцээр, олон улсын байгууллагын үйл ажиллагаанд оролцох зэрэг нь гадаад бодлогын хэрэгжилтэнд тавьсан зорилтуудыг биелүүлэхэд ашиглах хэрэгслийн алинд нь хамаарах вэ? (2 оноо)
    A. Мэдээлэл, суртал нэвтрүүлгийн
    B. Улс төрийн
    C. Эдийн засгийн
    D. Цэргийн
    E. Соёлын
54. Азийн хамтын ажиллагааны яриа хэлэлцээний механизм аль нь вэ? (2 оноо)
    A. АСЕАН
    B. ACD
    C. АПЕК
    D. АРФ
    E. АСЕМ
55. НҮБ-ын Нарийн бичгийн дарга нарын газрын бүрэлдэхүүн аль нь вэ? (2 оноо)
    A. Ерөнхий ассамблейн бүх төлөөлөгчид
    B. Гишүүн орнуудын төлөөлөгчид
    C. Зөвхөн өөрийн орон биш, харин НҮБ-ын гишүүн бүх улсад хүчин зүтгэх үүрэгтэй олон улсын энгийн албан хаагчид
    D. Олон улсын энх тайвныг сахиулах үүрэгтэй төлөөлөгчид
    E. Гишүүн орнууд дахь дэлхий дахины асуудлаар хэлэлцэн санаа бодлоо солилцох үүрэгтэй төлөөлөгч гишүүд

56. Монгол улсын гадаад бодлогын үйл ажиллагааг хамрах салбараар нь хэрхэн ангилдаг вэ? (2 оноо)
    - A. Улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан-технологи, соёл-хүмүүнлэгийн
    - B. Улс төр, эдийн засаг, боловсрол соёлын, хүмүүнлэгийн
    - C. Хоёр талын ба олон талт хамтын ажиллагаа
    - D. Бүс нутгийн ба тив дамнасан
    - E. Бүс нутгийн, олон улсын, тив дамнасан
57. Дараах бодомжуудаас аль нь үндэстэн дамнасан байгууллагыг тодорхойлж байна вэ? (2 оноо)
    - A. Дэлхийг хамарсан тал бүрийн үйл ажиллагаа явуулдаг байгууллага
    - B. Бүс нутаг дамнасан үйл ажиллагаа явуулдаг байгууллага
    - C. Салбар, үйлдвэр, аж ахуйн газар нь олон оронд байрладаг үйлдвэр үйлчилгээний том байгууллагууд
    - D. Тив дамнасан үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллага
    - E. Зөв хариулт алга

## ХОЁРДУГААР ХЭСЭГ

2.1. Өгөгдлийг зөв харгалзуулна уу. (5 оноо)

| | |
|---|---|
| A. Шууд татвар | 1. Аймаг нийслэлийн ИТХ-аас хувь хэмжээг нь тогтоосон бөгөөд тухайн нутаг дэвсгэрт үйлчлэх татвар |
| B. Шууд бус татвар | 2. Заавал төлөх төлбөрийн хэлбэрээр хариу төлбөргүйгээр улс, орон нутгийн төсөвт хуримтлуулдаг мөнгөн хөрөнгө |
| C. Улсын татвар | 3. Иргэн, байгууллагаас завсрын шат дамжлагагүйгээр орлогынх нь хэмжээтэй уялдуулан тогтоосон татвар |
| D. Орон нутгийн татвар | 4. Завсрын шат дамжлагыг дамжих замаар гүйцэтгэсэн ажил үйлчилгээ, бараа бүтээгдэхүүний борлуулалттай уялдуулан тогтоосон татвар |
| E. Албан татвар | 5. Төр, засгийн газраас хувь хэмжээг нь тогтоодог бөгөөд тухайн улсын нутаг дэвсгэрт нийтлэг үйлчлэх татвар |

2.2. Өгөгдлийг зөв тохируулна уу. (5 оноо)

| | |
|---|---|
| 1. Зүүний нам | A. Хүний эрх чөлөөний асуудлыг гол болгож, хөгжил дэвшилд уламжлалыг эрхэм болгодог |
| 2. Барууны нам | B. Нийгмийн чиг баримжааг гол болгож, хөгжил дэвшилд шинэчлэл хийхийг эрхэм болгодог |
| 3. Фракц | C. Нийгмийн өргөн баазад суурилдаг, дүрмээр нэгдсэн, хатуу гишүүнчлэлтэй, зохион байгуулалт, сахилга батын хувьд нарийн чанд намууд |
| 4. Олон түмний нам | D. Нийгмийн баазын хувьд өргөн биш, гол төлөв мэргэжлийн улс төрчид, улс төрийн зүтгэлтэн, улс төр, санхүүгийн элитэд тулгуурласан нам |
| 5. Боловсон хүчний нам | E. Өөрийн намын мөрийн хөтөлбөрөөс гажихгүй боловч түүнийг амьдралд хэрэгжүүлэх талаар өөр байр суурь, үзэл бодолтой, зохион байгуулалтын бүтэцтэй, намын доторх онцгой бүлэглэл |

2.3. Албан бус хяналтын хэв маягийг зөв тохируулна уу. (4 оноо)

| | |
|---|---|
| A. Нийгмийн урамшуулал | 1. Дургүйцсэн харц, шүүмжлэлт сануулга, бие махбодийн гэсгээл үзүүлэхээр заналхийлэх |
| B. Шийтгэл | 2. Эвлэрлийг хөхүүлж, гажуудлыг дам бууруулна |
| C. Итгэл үнэмшил | 3. Гажуудал хэмээн үзсэн зан төлөвийг хэвийн гэж үнэлэх |
| D. Хэм хэмжээг дахин үнэлэхүй | 4. Ухуулан сэнхрүүлэх аргаар гажуудалд нөлөөлөхүй ба аливаад сэтгэл зүрхнээсээ бат итгэх |

## ХУВИЛБАР F

## НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

1. … гэдэг бол соёлоос хожуу үүссэн ч даяарчлалын цар хүрээний ач холбогдолтой, нийгэм ба нийгэмлэгүүдийн соёлын хөгжлийн шат, түвшин болон тэдгээрийн өвөрмөц шинжийг тусгасан ойлголт юм. (2 оноо)
    - A. Нийгэм
    - B. Иргэншил
    - C. Соёл
    - D. Нийгэмшил
    - E. Иргэний нийгэм

2. Нийгмийн хөгжлийг байгалийн хүчин зүйлээр тайлбарлах үзэл хандлагуудад аль нь хамаарахгүй вэ? (2 оноо)
   A. Газар зүйн үзэл    B. Биологийн сургаал    C. Сэтгэл зүйн сургаал
   D. Хүн ам зүйн сургаал    E. Байгалийн шалгарлын хууль
3. Хууль зүй ба зан заншлаар тогтоогдсон, эрх үүргээ өв залгамжлан уламжлах нийгмийн бүлгийн хэв маягийг … гэнэ. (2 оноо)
   A. Боолчлол    B. Кастын хэв маяг    C. Язгуур угсааны хэв маяг
   D. Хаалттай хэв маяг    E. Тэгш бус байдал
4. Аль нь зөв бодомж вэ? (2 оноо)
   A. Нийгэмшилт бол хүмүүсийн хоорондын хамтач шинж мөн
   B. Нийгэмшилт бол хүн өөрийгөө нийгмийн эрх ашигт захируулахуй мөн
   C. Нийгэмшилт бол хүн өөртөө анхаарал тавих явдал мөн
   D. Нийгэмшилт бол тухайн хүн их хөдөлмөрлөх явдал мөн
   E. Нийгэмшилт бол хүн хэрэгцээгээ хангах үйл явц мөн
5. Аль бодомж нь зөв бэ? (2 оноо)
   A. Санкци нь тодорхой хүрээ цаг хугацаанд мөрдөгдөх дүрэм
   B. Санкци нь байнга дагаж мөрдөж байх ерөнхий дүрэм
   C. Санкци нь зөвхөн эерэг үнэлэмжтэй
   D. Санкци нь эерэг ба сөрөг үнэлэмжтэй
   E. Санкци нь нь зөвхөн сөрөг үнэлэмжтэй
6. Дараах үндэслэлүүдээс аль нь “Иргэний нийгэм” гэдэг ойлголтонд хамаарах вэ? (2 оноо)
   A. Дэлхий дахины түүхэн глобаль үйл явц
   B. Дэлхийн хамтын нийгэмлэгийн удирдлагын байгууллага
   C. Нийгмийн нэгдэл холбооны язгуур төлөөллүүдийн илрэл
   D. Уг чанартаа эрхэм дээд чин эрмэлзэл бөгөөд үе үеийн дэвшилтэт сэтгэгчдийн буй болгох гэж хүсэж мөрөөдөж ирсэн хийсвэр зүйл
   E. Нийгмийн тодорхой багц харилцаануудын цогц, дэд тогтолцоо
7. Аль нь орчин үеийн нийгмийн шинж вэ? (2 оноо)
   A. Хөдөлмөрийн хуваарь, төрөл мэргэжил нь байгалийнх байдаг
   B. Хувь хүмүүсийн хооронд албан биш хувийн харилцаа давамгайлдаг
   C. Хүмүүсийн харилцаа нь ёс заншил, зан үйлд тулгуурладаг
   D. Удирдлагын болхи системтэй
   E. Удирдлагын нийлмэл систем бий болсон
8. Орчин үеийн хөгжингүй, ардчилсан нийгэм дэх давхраажил аль дүр зурагт хамаарах вэ?

A. B. C. D. E.



9. Нийгэм түүхийг үзэх дараах онол сургаалын үзэл, гол төлөөлөгчдийг зөв харгалзуулна уу. (3 оноо)

| | |
|---|---|
| 1. Г. Лебон, Г.Тард | a. Нийгэм нь төрөл бүрийн элементээс тогтох бөгөөд тэр элемент нь бас бүтэцлэг шинжтэй, өөрийн үнэт чанар, хэм хэмжээ үүрэгтэй |
| 2. Э.Бернштейн, К.Каутский, К.Маркс, Ф.Энгельс | b. Нийгмийн хөгжилд үйлдвэрлэл, эдийн засаг чухал үүрэгтэй болох тухай эдийн засгийн онолтнууд |
| 3. Т.Парсонс, Д.Аберле, Р.Мертон | c. Нийгмийн хөгжил, оршин тогтнолыг гол төлөв нийгмийн олон түмний сэтгэл санааны зүй тогтлоор тайлбарладаг |

   A. 1a 2c 3b    B. 1c 2b 3a    C. 1c 2a 3b
   D. 1a 2b 3c    E. 1b 2a 3c
10. Нийгмийн институтыг зөв тодорхойлсон өгөгдлийг олно уу.
   A. Нийгэмд зөвшөөрч буй зоримж, зан заншил, дэг журам
   B. Нийгмийн хэм хэмжээний анхны хэлбэр
   C. Нийгмийн чухал хэрэгцээнүүдийг хангах, нийгмийн хэм хэмжээг зохицуулах чиг үүрэгтэй тохируулагч байгууламж
   D. Улс төрийн байгууламж
   E. Зөв тодорхойлолт алга

11. Тухайн нутаг дэвсгэр дээрх юмуу бүлгийн бүх хүнийг хамруулахгүйгээр харин тодорхой төлөөллийн үзүүлэлтүүдийг сонгон судлах нь …...... юм. (2 оноо)
    A. Анкетын арга  B. Түүврийн арга
    C. Ажиглалтын арга  D. Индукцийн арга
    E. Дедукцийн арга
12. ОХУ-ын Ерөнхий сайд В.Путин Монгол улсад албан ёсны айлчлал хийв. Энэ нь нийгмийн харилцааны аль түвшинд хамаарах вэ? (2 оноо)
    A. Бие хүмүүсийн хоорондын харилцаа  B. Бүлэг, нийтлэгийн хоорондын харилцаа
    C. Институт хоорондын харилцаа  D. Нийгэм хоорондын харилцаа
    E. Бие хүн, бүлэг нийтлэгийн хоорондын харилцаа
13. С.Баяр эрэгтэй хүн, МАХН-ын дарга, ази хүн, аав, ах, дүү, нийслэлийн иргэн, Монгол улсын ерөнхий сайд. Тэгвэл С.Баярын хувьд гол статус аль нь вэ?
    A. Эрэгтэй хүн  B. МАХН-ын дарга
    C. Ерөнхий сайд  D. Ази хүн
    E. Нийслэлийн иргэн
14. Манай улс социалист хөгжлийн замд орсныг гэрчлэх баримт бичиг аль нь вэ?
    A. 1924 оны үндсэн хууль  B. 1940 оны үндсэн хууль
    C. 1960 оны үндсэн хууль  D. 1992 оны үндсэн хууль
    E. Зөв хариулт алга
15. Нийгмийн институт болон удирдлагын аппаратын тусламжтайгаар субъект өөрийн ноёрхлоо тогтоох явдал аль нь вэ? (2 оноо)
    A. Засаглалын объект  B. Засаглалын субъект
    C. Засаглалын нөөц  D. Засаглалын механизм
    E. Засаглалын хэлбэр
16. Элитийн засаглалын хүч чадал, гол эх сурвалж нь дотоод зохион байгуулалт, эв нэгдэл хэмээн үзсэн эрдэмтэн аль нь вэ? (2 оноо)
    A. Г.Моска  B. Д.Истон  C. М.Вебер
    D. Г.Алмонд  E. К.Маркс
17. Цэрэг зэвсэглэл, арми, сүм хийд зэрэг субъектын шууд удирдлаган дор зохион байгуулалттай үүсгэн байгуулж, өөрийн үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд анх байгуулагдахдаа улс төрийн бус, мэргэжлийн гэмээр үүрэг зориулалттай байдаг бүлгийг хэрхэн нэрлэдэг вэ? (2 оноо)
    A. Аномик бүлэг  B. Эвлэл холбооны бус бүлэг
    C. Байгууллагажсан бүлэг  D. Эвлэл холбооны хэлбэртэй бүлэг
    E. Лоббийн бүлэг
18. Орчин үеийн бүгд найрамдах төрийн ангиллын үндсэн шалгуур аль нь вэ? (2 оноо)
    A. Төр засгийг хэн байгуулж, төр хэний өмнө хариуцлага хүлээж буй байдал
    B. Засгийн газрыг хэн байгуулж, засгийн газар хэний өмнө хариуцлага хүлээж буй байдал
    C. Онцгой эрх мэдэл бүхий хэсэг төрийг удирдаж буй эсэх
    D. Парламентыг хэн байгуулж, засгийн газар хэний өмнө хариуцлага хүлээж буй байдал
    E. Төрийн өндөрлөгүүдийг бүрдүүлэх үйл ажиллагааны чиг хандлага
19. Оролцооны дэмжлэгийн жишээ аль нь вэ? (2 оноо)
    A. Татвар төлөх  B. Цэргийн алба хаах
    C. Эд материалын дэмжлэг үзүүлэх  D. Төрийн бэлгэдлийг хүндэтгэн үзэх
    E. Сонгуульд саналаа өгөх
20. Төрийн нэр хүнд, уламжлалт чиг үүрэгт хүндэтгэлтэй ханддаг, нийтийн сайн сайхан, үндэсний уламжлалт үнэт зүйлийг хамгаалах үүднээс төрийн хууль ёсны оролцоо, зохицуулалтыг харьцангуй өндөр түвшинд хадгалдаг улс төрийн дэглэм аль нь вэ? (2 оноо)
    A. Либерал ардчилсан дэглэм  B. Консерватив ардчилсан дэглэм
    C. Охлократ ардчилсан дэглэм  D. Ардчилсан дэглэм
    E. Цэргийн дэглэм
21. Монгол улсад шүүх засаглалыг хэрэгжүүлэх байгууллага нь ....…. юм. (2 оноо)
    A. Шүүх  B. Прокурор  C. Үндсэн хуулийн цэц
    D. A, B, C хариулт зөв  E. Зөвхөн A ба B хариулт зөв
22. Монголын ард түмний түүхэн уламжлал, хүсэл тэмүүлэл, эв нэгдэл, шударга ёс, цог хийморийг илэрхийлдэг бэлгэ тэмдэг нь аль нь вэ? (2 оноо)
    A. Төрийн тамга, туг, далбаа  B. Төрийн сүлд, туг, далбаа, дуулал
    C. Хар сүлд, цагаан туг, дуулал  D. Цагаан туг, далбаа, дуулал
    E. Далбаа, төрийн тамга, дуулал

23. Францын гүн ухаантан Жан Боден төрийн бүрэн эрхийг хууль тогтоох, үл хуваагдах ба саадгүй эрх мэдэл гэж тодорхойлсон. Тэрээр ямар зорилгоор ийнхүү ангилсан бэ? (2 оноо)
    A. Францад хаант засгийн эрх дархыг хамгаалахад чиглэж байсан
    B. Францын хаант засгийг унагаахад чиглэж байсан
    C. Парламентат засаглалыг бий болгох зорилготой байсан
    D. Нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэглэгдэх хууль гаргаж хэрэгжүүлэх
    E. Үндэсний парламентаас дээгүүр ажиллаж чадах олон улсын байгууллага байгуулах
24. Хувьсгал, ангийн тэмцэл, сонгуулийн компани, төрийн тэргүүний айлчлал, дипломат гэрээ хэлэлцээр зэрэг нь аль ухагдахууныг илэрхийлэх вэ? (2 оноо)
    A. Улс төрийн хошуучлал B. Улс төрийн үйл ажиллагаа
    C. Улс төрийн оролцоо D. Улс төрийн харилцаа
    E. Улс төрийн соёл
25. Дараах газруудын алинд нь сонгуулийн сурталчилгаа явуулахыг хориглодог вэ? (2 оноо)
    A. Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага
    B. Сонгуулийн хороод
    C. Хүмүүнлэгийн байгууллага
    D. Буяны болон шашны байгууллага
    E. Дээрх бүгд
26. Сонгуулийн хэмжээс буюу босго тогтоох арга хэрэглэн босгыг сонгогчдын тооноос хамааруулан тойрог бүрт янз бүр байхаар, эсхүл улсын хэмжээгээр нэг адил байхаар тогтоодог нь сонгуулийн аль систем бэ? (2 оноо)
    A. Мажоритар B. Пропорциональ
    C. Холимог D. Сонгуулийн систем
    E. Суудал хуваарилах
27. Улс төрийн соёлын ангиллыг зөв харгалзуулна уу. (3 оноо)

| | |
|---|---|
| 1. Улс төрийн соёлыг хэрэгжих хүрээгээр нь | a. Нам, эвсэл холбоодын |
| 2. Улс төрийн соёлыг түвшингээр нь | b. Оролцогчдын буюу идэвхтэй, хамжлагын буюу албадлагын гэх мэт |
| 3. Улс төрийн соёлыг хөгжлийн байдлаар нь | c. Танин мэдэх, сэтгэл хөдлөлийн, үнэлэх |

    A. 1a 2b 3c B. 1c 2b 3a C. 1a 2c 3b D. 1c 2a 3b E. 1b 2c 3a
28. Ардчиллын бодит үйл явц дахь иргэдийн оролцоо, идэвх суларч байгаагийн шалтгаан юу вэ? (2 оноо)
    A. Сонгуульд оролцох сонгогчдын хувь оролцоо буурч байна
    B. Олон түмэн итгэл алдрахын хэрээр засгийн газар иргэдтэй харилцах шинэ арга замыг эрэлхийлэх шахалтанд орж байна
    C. Иргэдийн оролцоо нь бодлого боловсруулах хязгааргүй их бололцоо болж чадна
    D. Хариуцлага тооцох механизм адил тэгш үйлчилдэггүй
    E. Дээрх бүгд
29. Үнэ буурвал эрэлтийн тоо хэмжээ нэмэгдэж, үнэ өсөхөд эрэлтийн тоо хэмжээ буурах барааг ямар бараа гэх вэ? (2 оноо)
    A. Хэвийн бараа B. Онцгой бараа
    C. Өргөн хэрэглээний бараа D. Энгийн бараа
    E. Дорд бараа
30. Ядуучууд бусдаас хэр зэрэг доогуур амьдарч байгааг харуулах үзүүлэлт бөгөөд тодорхой хэмжээний хэрэгцээг хангаж чадахгүй байгаа нөхцлийг … гэнэ. (2 оноо)
    A. Хүнс тэжээлийн ядуурал B. Хэрэгцээний ядуурал
    C. Үнэлгээний ядуурал D. Харьцангуй ядуурал
    E. Нэн ядуурал
31. Дуртай тоо хэмжээгээр бэлэн байдаггүй баялаг, үйлчилгээг үйлдвэрлэх, хуваарилах, хэрэглэхтэй холбогдсон бүхий л үйл явцын нийлбэр цогц нь … юм. (2 оноо)
    A. Эдийн засгийн онол B. Эдийн засгийн үндсэн асуудал
    C. Эдийн засаг D. Макро эдийн засаг
    E. Микро эдийн засаг
32. Соёл, ахуйн үйлчилгээ, гоёл чимэглэлийн зүйлс, тансаг эдлэлийн шаардлагыг аль хэрэгцээнд хамааруулах вэ? (2 оноо)
    A. Хэрэгцээ B. Материаллаг хэрэгцээ
    C. Анхдагч хэрэгцээ D. Хоёрдогч хэрэгцээ
    E. Бүлгийн хэрэгцээ

33. … нь захиргаадалтын эдийн засгийн үндсэн шинж мөн. (2 оноо)
   A. Хувийн өмч
   B. Ашгийн төлөө хөөцөлдөх
   C. Эдийн засагт төрийн оролцоо хязгаарлагдмал байх
   D. Зан заншил, уламжлалд тулгуурлах
   E. Эдийн засагт төрийн оролцоо их байх
34. Оюуны үйлчилгээнд дараах өгөгдлийн аль нь орох вэ? (2 оноо)
   A. Нийтийн хоол B. Ном бичих C. Эмчийн үзлэг
   D. Талх үйлдвэрлэх E. Хувцас үйлдвэрлэх
35. Ажил эрхлэлгүй орлого ологчид гэж хэнийг хэлж болох вэ? (2 оноо)
   A. Хууль бус бизнесийн зардал ба татвараас зайлсхийгчид
   B. Мэдэгдэлгүй нуун дарагдуулж олж буй орлогын янз бүрийн эх үүсвэрээр амьдрагчид
   C. Давхар ажил эрхлэгчид
   D. Албаны бэлэн мөнгөөр хувийн арилжаа наймаа хийгчид
   E. Ажилгүй гэж бүртгүүлэн улсаас тэтгэмж тусламж авдаг хэрнээ засаг захиргаанд мэдэгдэлгүй орлого олдог хүмүүс
36. Аймгийн Засаг даргын тамгын газрын шинэ барилгыг Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн газраас 250 сая төгрөгөөр үнэлжээ. Уг барилга өмчийн аль хэлбэрт хамаарах вэ? (2 оноо)
   A. Төрийн өмч B. Төрийн нийтийн зориулалттай өмч
   C. Сангийн өмч D. Орон нутгийн өмч
   E. Төрийн өөрийн өмч
37. Хөдөлмөрийн бүтээмжид нөлөөлдөг хүчин зүйлсийг дурдахдаа илүүц зүйл оруулсан бол аль нь вэ? (2 оноо)
   A. Ажиллагсдын боловсрол B. Ажиллагсдын урам зориг , сонирхол
   C. Ажиллагсдын гарал, нийгмийн байдал D. Хөдөлмөрийн зохион байгуулалт
   E. Тоног төхөөрөмжийн чанар
38. Нийлүүлэлт нэмэгдвэл ........ . (2 оноо)
   A. Үнэ өснө, тоо хэмжээ өснө B. Үнэ буурна,тоо хэмжээ буурна
   C. Үнэ буурна, тоо хэмжээ өснө D. Үнэ өснө, тоо хэмжээ буурна
   E. Тэнцвэрт үнэ тогтоно
39. Хэрэглээний үнийн индексийг хэрхэн тодорхойлдог вэ? (2 оноо)
   A. Тухайн онд авсан сагсны зах зээлийн үнийг суурь жилийн барааны сагсны үнэд харьцуулна
   B. Тухайн онд авсан сагсны зах зээлийн үнийг өмнөх жилүүдийн барааны сагсанд харьцуулна
   C. Инфляцийн түвшний өөрчлөлтөөр тодорхойлно
   D. Тодорхой хугацааны завсар дахь үнийн нийт түвшний өөрчлөлтийн хувиар илэрхийлнэ
   E. Аль алинаар нь тодорхойлж болно
40. Монгол улсын Төв банк нь тайлангаа хаана гаргах вэ? (2 оноо)
   A. Дээд шүүхэд B. Засгийн газарт C. УИХ-д
   D. Сангийн яаманд E. Хэнд ч тайлагнахгүй
41. Өмч нь эдийн засгийн болоод хууль зүйн ойлголт юм. Доорх өгөгдлөөс аль нь эдийн засгийн талыг илэрхийлэх вэ? (2 оноо)
   A. Өмчийг эзэмших B. Ашиглах C. Бэлэглэх
   D. Арвижуулах E. Худалдах
42. Татвар тооцох, ноогдуулах журмыг зөв харгалзуулна уу. (3 оноо)

| | |
|---|---|
| 1. Декларацийн арга | a. Цалин, хөдөлмөрийн хөлс, ноогдол ашиг , хадгаламжийн хүүгийн орлогод татвар ноогдуулахад тухайн орлогыг олгож байгаа байгууллага хэрэглэх арга |
| 2. Кадастрын арга | b. Гол төлөв газар, үл хөдлөх хөрөнгө, тээврийн хэрэгслийн бүртгэл хөтөлж, тэдгээрт хөрөнгийн татвар ноогдуулах журам |
| 3. Суутгалын арга | c. Татвар төлөгч тодорхой хугацаанд олсон орлогоо татварын албанд тусгай маягтаар мэдэгдэх |

   A. 1b 2c 3a B. 1c 2b 3a C. 1c 2a 3b D. 1b 2a 3c E. 1a 2b 3c
43. Оёдлын үйлдвэрт хэдэн шинэ машин нэмж суурилуулав. Ингэснээр … (2 оноо)
   A. Нийт бүтээмж өснө
   B. Нийт бүтээмж буурна
   C. Тоног төхөөрөмжийн бүтээмж буурна
   D. Тоног төхөөрөмжийн бүтээмж өснө
   E. Нийт гарц мэдэгдэхгүй байгаа тул бүтээмжийн өөрчлөлтийг тооцох боломжгүй

44. Татвар ноогдуулалт нь сангийн, зохицуулагч гэсэн хоёр үндсэн чиг үүрэгтэй. Сангийн чиг үүрэг давамгайлах бодлого явуулбал ямар үр дагаварт хүрч болох вэ? (2 оноо)
    A. Аж ахуйн нэгжүүдийг дампууруулах B. Барааны хэрэглээг хязгаарлах
    C. Импортыг хязгаарлах D. Бизнес эрхлэгчдийн урмыг хугалахад хүргэх
    E. Төсвийн хямралд хүргэх аюултай
45. Зан байдлын дүрүүд аль нь вэ? (2 оноо)
    A. Зан үйл B. Ёс заншил C. Уламжлал
    D. Дээрх бүгд E. A ба C хариулт зөв
46. Хүмүүс өөрсдийнхөө янз бүрийн үйл ажиллагааг ивээн тэтгэж байдаг янз бүрийн бурхад оршдог хэмээн сэтгэж олон бурхны тухай хийсвэрлэл гаргаж ирсэн. Энэ нь шүтлэгийн аль хэлбэр вэ? (2 оноо)
    A. Монотеизм B. Политеизм C. Анимизм
    D. Тотемизм E. Фетишизм
47. Оюуны соёлын элементүүдийг дурдахдаа илүүц зүйл оруулсан бол аль нь вэ? (2 оноо)
    A. Мэдлэг B. Хэл яриа C. Эрх мэдэл
    D. Домог E. Зан заншил
48. Өрнөдөд нэрд гарсан сөрөг соёлын жишээ аль нь вэ? (2 оноо)
    A. Богема буюу задгай сэхээтнүүд B. 60-70-аад оны хиппи
    C. Ёс заншлын онцгой хэлбэр болох Табу D. Дээрх бүгд
    E. A ба B хариулт зөв
49. Төрийн далбаа нь эх оронч үзэл, эх орноороо бахархах үзлийг төрүүлдэг гэдэг утгаар нь эвлэлдэн нэгдэх болон үзэн ядах утгаар ч түүнд ханддаг . Энэ нь соёлын элементийн хувьд алинд нь хамаарах вэ? (2 оноо)
    A. Үндэсний үзэл B. Бэлгэ тэмдгийн тогтолцоо
    C. Эх оронч үзэл D. Үнэт чанар, хэм хэмжээний тогтолцоо
    E. Хэм хэмжээний тогтолцоо
50. Хип хоп урлагийг өсвөр үеийнхэн ихэд таашааж байхад ахмадууд төдийлөн таашаадаггүй нь дараах өгөгдлийн алинаар илүү тайлбарлагдах вэ? (2 оноо)
    A. Соёлын өөрчлөлтийн эх үүсвэр
    B. Соёлын хэм хэмжээ
    C. Субъектээс хамаарч үнэлэмж нь өөр өөр байх
    D. Соёлын олон талт байдал
    E. Нийтийн соёл нь үнэ цэнийн хувьд ардын соёлд хүрдэггүй
51. Соёлын хэлбэрүүдийг зөв харгалзуулна уу. (3 оноо)

| | |
|---|---|
| 1. Соёлыг өргөжин тэлэх хандлагаар нь ангилах ангилал | a. Мэргэжлийн, үндэсний, шашны |
| 2. Соёлын босоо чиглэл дэх ангилал | b. Иргэншлийн, бүс нутгийн, угсаатны, үндэсний, орон нутгийн хэв маягийн |
| 3. Дэд соёлын ангилал | c. Элитийн, ардын, нийтийн, зонхилогч, дэд, сөрөг |

    A. 1a 2b 3c B.1a 2c 3b C. 1b 2a 3c D.1b 2c 3a E.1c 2b 3a
52. Дараах үзэгдлүүдээс аль нь нийгэмд илүү хор уршиг авчрах вэ? (2 оноо)
    A. Хулгай, дээрэм тонуул B. Садар самуун явдал
    C. Нийтийг хамарсан архидан согтуурах явдал D. Тамхийг өргөн хэрэглэх
    E. Этгээд хувцаслалт
53. Эдийн засгийн чадавхийг бусдын эдийн засагт, улмаар улс төрийн бодлогод нөлөөлөхөд ашиглах зэрэг нь гадаад бодлогын хэрэгжилтэнд тавьсан зорилтуудыг биелүүлэхэд ашиглах хэрэгслийн алинд нь хамаарах вэ? (2 оноо)
    A. Мэдээлэл, суртал нэвтрүүлгийн B. Улс төрийн
    C. Эдийн засгийн D. Цэргийн
    E. Соёлын
54. Ази, Номхон далайн бүс нутгийг бүхэлд нь хамарсан өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулдаг бүсийн чуулга аль нь вэ? (2 оноо)
    A. АСЕАН B. ШХАБ C. АПЕК D. АРФ E. АСЕМ
55. НҮБ-ын үндсэн зорилтыг тэмдэглээрэй. (2 оноо)
    A. Даян дэлхийд энх тайвныг сахин хамгаалах
    B. Үндэстэн, ард түмний хооронд нөхөрсөг харилцааг хөгжүүлэх
    C. Хүний эрх, эрх чөлөөг бүдүүлгээр үй олноор зөрчихтэй тэмцэх, бичиг үсэг үл мэдэх явдал, өвчин эмгэг, өлсгөлөн ядуурлыг даван туулахад туслах, хамтран ажиллах
    D. Гишүүн орнуудынхаа тавьж буй зорилтыг хэрэгжүүлэхэд туслах
    E. Дээрх бүгд

56. Аль нь Монгол улсын гадаад бодлогын өнөөгийн зарчим биш вэ? (2 оноо)
    A. Үндэсний эрх ашгийг дээдлэх B. Идэвхтэй C. Нээлттэй
    D. Энх тайвнаар зэрэгцэн орших E. Олон тулгуурт
57. Дараах бодомжуудын аль нь "Олон улсын байгууллага" хэмээх ойлголтыг тодорхойлохгүй вэ? (2 оноо)
    A. Хоёр ба түүнээс дээш тооны улс оролцож байгуулсан хамтын байгууллага
    B. Олон улсын эрх зүйн хүрээнд үүсгэн байгуулагчдын хэлэлцэн тохирсон хэм хэмжээг удирдлага болгон үйл ажиллагаа явуулна
    C. Улс улсын аж ахуйн байгууллагатай харилцахаас гадна нэлээд тохиолдолд төрийн байгууллагуудтай харилцан, заримдаа гэрээ хэлэлцээр байгуулан ажиллана
    D. Улсууд өөрсдийн сонирхол хэрэгцээг хангахад нийцтэй байдлыг бий болгох, хүчин чармайлтаа нэгтгэх зорилгоор бий болгодог
    E. B ба D хариулт тодорхойлохгүй

## ХОЁРДУГААР ХЭСЭГ

2.1. Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу. (5 оноо)

| | |
|---|---|
| A. Бусад оронтой хийх олон улсын тооцоонд ашиглаж буй тухайн орны мөнгөний нэгж | 1. Чөлөөтэй хөрвөх валют |
| B. Нэг л орны дотор үйлчилж, бусад улсын валютаар арилжигдахгүй үндэсний валют | 2. Валютын арилжааны ханш |
| C. Гадаадын аль ч валютаар чөлөөтэй хязгаарлалгүй арилжигдах валют | 3. Хязгаартай валют |
| D. Өөр улсын мөнгөний нэгжээр илэрхийлсэн аль нэг улсын мөнгөний нэгжийн үнэ | 4. Үндэсний валют |
| E. Гадаад худалдааны үйл ажиллагаа явуулах, гадаадын хөрөнгө оруулалтын тооцоонд үнэ тодорхойлоход ашиглаж буй тэргүүлэх орнуудын үндэсний мөнгө-зээллэгийн хэрэгсэл | 5. Нөөц валют |

2.2. Нийгмийн тухай үзэл, хандлагуудыг зөв харгалзуулна уу. (5 оноо)

| | |
|---|---|
| A. Тогтолцооны хандлага | 1. Нийгэм нь бүхэллэг тогтолцоо болохынхоо хувьд эдийн засаг, нийгэм, улс төр, үзэл суртал зэрэг дэд тогтолцоонуудад хуваагддаг |
| B. Шалтгаант чанарын хандлага | 2. Ангиудын хоорондын зөрчил нийгмийн үндэс язгуурт байдаг |
| C. Функционализм | 3. Нийгэм нь нягт хэлхээ холбоонд оршдог элементүүдийн нийтлэг тогтолцоо |
| D. Мөргөлдөөний онол | 4. Үүргээ алдах явдал үнэндээ тохиолддог бөгөөд энэ нь аяндаа засагдах буюу эцэс сүүлдээ нийгэмд бэхжин тогтож болно |
| E. Индивидуалист онол | 5. Нийгэм нь бие хүмүүс, тэдгээрийн хоорондын социал харилцааны цогц |

2.3. Өгөгдлийг зөв тохируулна уу. (4 оноо)

| | |
|---|---|
| A. Хүний эрх чөлөөний асуудлыг гол болгож, хөгжил дэвшилд уламжлалыг эрхэм болгодог | 1. Барууны нам |
| B. Нийгмийн чиг баримжааг гол болгож, хөгжил дэвшилд шинэчлэл хийхийг эрхэм болгодог | 2. Зүүний нам |
| C. Нийгмийн баазын хувьд өргөн биш, гол төлөв мэргэжлийн улс төрчид, улс төрийн зүтгэлтэн, улс төр, санхүүгийн элитэд тулгуурласан нам | 3. Боловсон хүчний нам |
| D. Өөрийн намын мөрийн хөтөлбөрөөс гажихгүй боловч түүнийг амьдралд хэрэгжүүлэх талаар өөр байр сууръ, үзэл бодолтой, зохион байгуулалтын бүтэцтэй, намын доторх онцгой бүлэглэл | 4. Фракц |

## ХУВИЛБАР Н

## НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

1. Нийгэм хэрхэн хөгждөг вэ? (2 оноо)
   A. Нийгэм бол байнга хөгжиж байдаг амьд организм
   B. Нийгэм нь түүхэн тодорхой үед л хөгждөг
   C. Нийгэм бол хамтын ажиллагааны үр дүн мөн
   D. Нийгэм бол оюуны үйлдвэрлэл мөн
   E. Нийгэм нь харилцан үйлчлэлийн бүтээгдэхүүн
2. Нийгмийн хөгжлийг нийгмийн хүчин зүйлээр тайлбарлах үзэл чиглэлд аль нь хамаарахгүй вэ? (2 оноо)
   A. Сэтгэл зүйн сургаал B. Эдийн засгийн онол C. Элитийн онол
   D. Хүн ам зүйн сургаал E. Иргэншлийн онол
3. Нийгэм нь шатлал бүхий бүлгүүдэд хуваагдах бөгөөд дотроо шатлан захирах ёсонд хатуу тогтоосон байр суурь эзэлдэг эрэмбэ бүхий хаалттай бүлгийг … гэнэ. (2 оноо)
   A. Боолчлол B. Кастын хэв маяг C. Язгуур угсааны хэв маяг
   D. Хаалттай хэв маяг E. Тэгш бус байдал
4. Нийгмийн тэгш бус байдлыг хэрхэн ангилж болох вэ? (2 оноо)
   A. Эд хөрөнгийн, эрх мэдлийн, зэрэг зиндааны, боловсролын
   B. Эд хөрөнгийн, язгуур угсааны, шашны, яс үндэсний
   C. Эрх мэдлийн, зэрэг зиндааны, язгуур угсааны, авьяас чадварын
   D. Зэрэг зиндааны, овсгоо самбааны, эрдэм мэдлэгийн, эрх мэдлийн
   E. Эд баялгийн, эрх мэдлийн, албан тушаалын, язгуур угсааны
5. Н.Багабандийн тухайд мастер статуст аль өгөгдөл тохирох вэ? (2 оноо)
   A. Монгол улсын ерөнхийлөгч асан B. Оюунбилэгийн нөхөр
   C. Нацагийн хүү D. МАХН-ын дарга асан
   E. Улс төрч
6. Аль нь орчин үеийн нийгмийн шинж биш вэ? (2 оноо)
   A. Хөдөлмөрийн хуваарь гүнзгий хөгжсөн, мэргэжил нь боловсролтой холбоотой ажлын туршлага дээр тулгуурласан байдаг
   B. Хүмүүсийн хоорондын харилцаа нь үүргийн шинжтэй байдаг
   C. Нийгмийн харилцааг бичигдмэл хууль, гэрээ хэлэлцээр гэх мэт албан ёсны хэм хэмжээгээр зохицуулдаг
   D. Нийгмийн гишүүд нь янз бүрийн нийгмийн бүлэг , давхраа, институтуудын харилцаагаар холбогдсон байна
   E. Хүмүүсийн харилцаа нь ёс заншил, зан үйлд тулгуурласан байдаг
7. 1920-иод оноос өмнөх Монголын хүн амын давхраажил нь аль дүр зурагт хамаарах вэ? (2 оноо)

   A. B. C. D. E.



8. Иргэний нийгмийн тухай үзэл, ойлголтуудыг зөв харгалзуулна уу. (3 оноо)
   1. Социологийн чиглэлт ойлголт — a. Иргэний нийгэм бол бидний ухамсар, санаа зоригоос хамаарахгүйгээр оршин тогтнож байгаа нийгмийн бодит байдлын тусгал
   2. Үзэл суртлын чиглэлт ойлголт — b. Иргэний нийгэм бол уг чанартаа эрхэм дээд чин эрмэлзэл бөгөөд манай гарагийн үе үеийн тэргүүний, дэвшилтэт сэтгэгчдийн буй болгох гэж мөрөөдөж ирсэн хийсвэр зүйл
   3. Хууль зүйн чиглэлт ойлголт — c. Нийгэмд ардчилсан эрхзүйт төрийг төлөвшүүлэх нь иргэний нийгмийн хөгжлийн үндэс

   A. 1c 2a 3b B. 1b 2c 3a C. 1a 2b 3c
   D. 1a 2c 3b E. 1c 2b 3a

9. Нийт ард түмний хэрэгцээ, ашиг сонирхлыг хэрэгжүүлэх явц дахь хүмүүсийн харилцан үйлдэл ба харилцааг зохицуулан тохируулах чиг үүрэг нийгмийн амьдралын аль хүрээнд хэрэгжих вэ? (2 оноо)
   A. Улс төрийн хүрээнд
   B. Социал хүрээнд
   C. Эдийн засгийн хүрээнд
   D. Оюуны амьдралын хүрээнд
   E. Зөв хариулт алга
10. Баяр, Наран хоёр гэрлэснийхээ дараа хотод аав, ээжийнхээ дэргэд биш харин хөдөө ажиллаж амьдрахаар шийджээ. Энэ нь дараах өгөгдлүүдийн алинд нь хамаарах вэ? (2 оноо)
   A. Полигени
   B. Матриархаль
   C. Неолокаль
   D. Эндогами
   E. Патрилокаль
11. Овгуудын хөтөлж байсан угийн бичгийг судлахдаа гэр бүлийн цусан болон ясан төрлийн үе удам, гишүүдийн хүйс, дундаж наслалт зэргийг тус тусад нь авч үзэх нь дараах аргуудын алинд нь илүү хамаарах вэ? (2 оноо)
   A. Анкетын арга
   B. Түүврийн арга
   C. Анализын арга
   D. Индукцийн арга
   E. Дедукцийн арга
12. Тодорхой газар нутгийн хүрээнд бүрэлдэн тогтсон соёл, сэтгэл зүйн ерөнхий шинж онцлогийг хадгалсан, урт удаан хугацааны холбоотой бүлэг хүмүүсийн тогтвортой цогц аль нь вэ? (2 оноо)
   A. Аймаг
   B. Овог
   C. Үндэстэн
   D. Ястан
   E. Угсаатан
13. Тамирчид зуны аялал зохион байгуулахаар “Тэрэлж жуулчин” компанитай гэрээ байгуулав. Уг өгөгдөл нийгмийн харилцааны аль түвшинд хамаарах вэ? (2 оноо)
   A. Бие хүмүүсийн хоорондын харилцаа
   B. Байгууллага ба бүлэг, нийтлэгийн хоорондын харилцаа
   C. Институт хоорондын харилцаа
   D. Нийгэм хоорондын харилцаа
   E. Бие хүн, бүлэг нийтлэгийн хоорондын харилцаа
14. Монгол улсын Үндсэн хуульд зааснаар прокурор нь дараах статустай албан тушаалтан юм. Тухайн албан тушаалтанд хамааралгүй өгөгдлийг олно уу. (2 оноо)
   A. Шүүх
   B. Хэрэг бүртгэх
   C. Мөрдөн байцаах үйл ажиллагаанд хяналт тавих
   D. Ял эдлүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих
   E. Шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох
15. Иргэд, нийгмийн бүлэг , нийгэм бүхэлдээ … болно. (2 оноо)
   A. Засаглалын объект
   B. Засаглалын субъект
   C. Засаглалын нөөц
   D. Засаглалын механизм
   E. Засаглалын хэлбэр
16. Улс төрийн системийн оролт, гаралт нь дараах ойлголтуудын алинаар нь дамжин хоорондоо харилцан шүтэлцэж байдаг вэ? (2 оноо)
   A. Дэмжлэг
   B. Шаардлага
   C. Эргэх холбоо
   D. Үйлдэл
   E. Шийдвэр
17. Сонгуулийн эрх, сонгуулийн зарчим, сонгуулийн дүнг гаргах, суудал хуваарилах арга зэргийг тодорхойлсон хэм хэмжээний цогцыг …..... гэдэг . (2 оноо)
   A. Сонгууль
   B. Сонгуулийн систем
   C. Сонгуулийн компани
   D. Сонгуулийн зарчим
   E. Иргэдийн оролцоо
18. Төрийг эртний, дорно дахины, грек-ромын, дундад үеийн, шинэ үеийн хэмээн ангилсан нь төрийн хэв маягийн ангиллын алинд нь хамаарах вэ? (2 оноо)
   A. Эртний ангилал
   B. Марксист ангилал
   C. Иргэншлийн хандлага
   D. Түүхэн хөгжлийн ангилал
   E. Орчин үеийн ангилал
19. Улс төрийн намын дотоод чиг үүрэгт аль нь хамаарах вэ? (2 оноо)
   A. Улс төрийн боловсон хүчнийг шилж сонгосны үндсэн дээр намын элит хэсэг ба улс төрийн лидерүүдийг бий болгох
   B. Иргэдийн улс төрийн идэвхийг сэргээн, аль болох улстөржүүлэх
   C. Намын хяналтын үүрэг
   D. Засгийн эрхийн төлөө тэмцэх
   E. Бусад намуудтай эвсэх боломжийг судлах
20. Төрийн нэр хүнд, уламжлалт чиг үүрэгт хүндэтгэлтэй ханддаг, нийтийн сайн сайхан, үндэсний уламжлалт үнэт зүйлийг хамгаалах үүднээс төрийн хууль ёсны оролцоо, зохицуулалтыг харьцангуй өндөр түвшинд хадгалдаг улс төрийн дэглэм аль нь вэ? (2 оноо)
   A. Либерал ардчилсан дэглэм
   B. Консерватив ардчилсан дэглэм
   C. Охлократ ардчилсан дэглэм
   D. Ардчилсан дэглэм
   E. Цэргийн дэглэм

21. Монголын ард түмний түүхэн уламжлал, хүсэл тэмүүлэл, эв нэгдэл, шударга ёс, цог хийморийг илэрхийлдэг бэлгэ тэмдэг нь аль вэ? (2 оноо)
    A. Төрийн тамга, туг, далбаа
    B. Төрийн сүлд, туг, далбаа, дуулал
    C. Хар сүлд, цагаан туг, дуулал
    D. Цагаан туг, далбаа, дуулал
    E. Далбаа, төрийн тамга, дуулал
22. Хувьсгал, ангийн тэмцэл, сонгуулийн компани, төрийн тэргүүний айлчлал, дипломат гэрээ хэлэлцээр зэрэг нь аль ухагдахууныг илэрхийлэх вэ?
    A. Улс төрийн хошуучлал
    B. Улс төрийн үйл ажиллагаа
    C. Улс төрийн оролцоо
    D. Улс төрийн харилцаа
    E. Улс төрийн соёл
23. Сонгууль жинхэнэ утгаараа чөлөөт, шударга явагдах гол нөхцөл нь юу байж болох вэ? (2 оноо)
    A. Чөлөөт байдлыг хангах
    B. Нийгмийг ардчилах, улсаа удирдахад оролцох эрхийг хэрэгжүүлэх
    C. Төрийн үйл хэрэгт оролцох эрх
    D. Сонгууль өөрийн утгаараа ардчилал биш
    E. Хүний үндсэн эрхийг сахин хангаж, хүний эрхийн олон улсын стандартад нийцсэн байх
24. Төрийн байгууллагууд эрх мэдлээ буруу ашиглахын эсрэг тэмцэх хамгийн сайн арга аль нь вэ?
    A. Захиргааны шүүхэд хандах
    B. Ерөнхийлөгч хориг тавих
    C. Үндсэн хуулийн цэцэд хандах
    D. Хэвлэл мэдээллээр цацах
    E. Дээд шүүхэд хандах
25. Монгол улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 5-д, "... Өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд мөнгөний тусламж авах эрхтэй" гэж заасан нь .... юм. (2 оноо)
    A. Манай төр социал төрийн баримжаатай гэдгийн баталгаа
    B. Манай төр эрх зүйт төрийн баримжаатай гэдгийн баталгаа
    C. Хүмүүсийн байгалиас заяасан тэгш бус байдлыг засч залруулах
    D. Эдийн засгийн либерализм зах зээлийн зохицуулалтад давуу байдал олгодгийн баталгаа
    E. Төр, иргэний нийгэм хоёр эрхзүйт хуулийн үндсэн дээр тэнцвэртэй орших
26. Сонгуулийн хэмжээс буюу босго тогтоох арга хэрэглэн, босгыг сонгогчдын тооноос хамааруулан тойрог бүрт янз бүр байхаар, эсвэл улсын хэмжээгээр нэг адил байхаар тогтоодог нь сонгуулийн аль систем бэ? (2 оноо)
    A. Мажоритар
    B. Пропорциональ
    C. Холимог
    D. Сонгуулийн систем
    E. Суудал хуваарилах
27. Төрийн засаглалын хэлбэрүүдийг зөв тохируулаарай. (3 оноо)

| | |
|---|---|
| 1. Хаант засаглалын онцлог | a. Гадаад бодлогыг чиглүүлэн удирдах хариуцлагыг ерөнхийлөгч хүлээнэ |
| 2. Ерөнхийлөгчийн засаглалын онцлог | b. Ерөнхийлөгч төрийн тэргүүн, улс үндэстний тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын баталгаа, улс төрийн янз бүрийн хүчнүүдийн хоорондын маргааныг зохицуулагчийн үүргийг гүйцэтгэж байдаг |
| 3. Парламентын засаглалын онцлог | c. Үе залгамжлан эсвэл зарим тохиолдолд сонгогдсон нь засгийн эрхийг барина |

    A. 1a 2b 3c
    B. 1a 2c 3b
    C. 1b 2c 3a
    D. 1c 2b 3a
    E. 1c 2a 3b
28. Засаглалын нэр хүнд нь түүнийг хүчирхэг байлгах нэн чухал асуудал. Тэгвэл нэр хүнд бүрэлдэх нөхцөл байдал нь юу байж болох вэ? (2 оноо)
    A. Хараат бус байх нь засгийн нэр хүндэд эерэг тусдаг
    B. Засаглал нутаг усны, үндэсний уур амьсгалтай байх нь нийгмийн зүгээс дэмжлэг хүлээхэд нэмэртэй
    C. Төр засгийг бурханчлан шүтэх ард түмний итгэл зайлшгүй байх ёстой бөгөөд үүнгүйгээр нийгэмд хүндэтгэл олж авахад бэрхшээлтэй
    D. Дээрх бүгд
    E. Зөвхөн B, C хариулт
29. Хүмүүсийн ашиг хонжоо олох гэсэн аж ахуйн үйл ажиллагаа нь тэднээс үл шалтгаалах бодит хуулиар зохицуулагдаж байдаг тухай онол аль ойлголттой тохирох вэ? (2 оноо)
    A. Эдийн засгийн онол
    B. Төрийн зохицуулалт
    C. Марксист эдийн засгийн онол
    D. Үл үзэгдэгч гарын онол
    E. Монетаризм

30. Хоол хүнс, хувцас, орон байр, оюун санаа, соёлын үнэт зүйлс, боловсрол, эрүүл мэнд, хүний эрх гэх мэт хүн бүрт шаардагдах бүх зүйлийг … гэнэ. (2 оноо)
    A. Материаллаг хэрэгцээ
    B. Хэрэгцээ
    C. Хувийн хэрэгцээ
    D. Нийгмийн хэрэгцээ
    E. Анхдагч хэрэгцээ
31. … нь үйлдвэрлэлийн зардлаас давсан илүүдэл орлого юм. (2 оноо)
    A. Үр ашиг
    B. Ашиг
    C. Зардал
    D. Нийт орлого
    E. Бүтээмж
32. Тодорхой хугацааны завсар дахь үнийн нийт түвшний өөрчлөлтийг хувиар илэрхийлсэн ухагдахууныг юу гэх вэ? (2 оноо)
    A. Инфляци
    B. Дефляци
    C. Хэрэглээний үнийн индекс
    D. Инфляцийн түвшин
    E. Үнийн индекс
33. … нь захиргаадалтын эдийн засгийн үндсэн шинж мөн. (2 оноо)
    A. Хувийн өмч
    B. Ашгийн төлөө хөөцөлдөх
    C. Эдийн засагт төрийн оролцоо хязгаарлагдмал байх
    D. Зан заншил, уламжлалд тулгуурлах
    E. Эдийн засагт төрийн оролцоо их байх
34. Оюуны үйлчилгээнд дараах өгөгдлийн аль нь орохгүй вэ? (2 оноо)
    A. Хоолны жор
    B. Ном бичих
    C. Эмчийн үзлэг
    D. Барилгын зураг төсөл
    E. Ном хэвлэх
35. Ажил эрхлэлгүй орлого ологчид гэж хэнийг хэлж болох вэ? (2 оноо)
    A. Хууль бус бизнесийн зардал ба татвараас зайлсхийгчид
    B. Мэдэгдэлгүй нуун дарагдуулж олж буй орлогын янз бүрийн эх үүсвэрээр амьдрагчид
    C. Давхар ажил эрхлэгчид
    D. Албаны бэлэн мөнгөөр хувийн арилжаа наймаа хийгчид
    E. Ажилгүй гэж бүртгүүлэн улсаас тэтгэмж тусламж авдаг хэрнээ засаг захиргаанд мэдэгдэлгүй орлого олдог хүмүүс
36. Монголын ард түмний хандив, төр засгийн дэмжлэгтэйгээр бүтээн залсан төрийн их шүтээн "Мэгжид Жанрайсаг" бурхан өмчийн аль хэлбэрт хамаарах вэ? (2 оноо)
    A. Төрийн нийтийн зориулалттай өмч
    B. Орон нутгийн өмч
    C. Шашны байгууллагын өмч
    D. Холимог өмч
    E. Төрийн бус байгууллагын өмч
37. ҮНБ-ийг зарцуулалтаар тооцохдоо ямар үзүүлэлтийг харгалзахгүй вэ? (2 оноо)
    A. Түрээс
    B. Хэрэглээ
    C. Хөрөнгө оруулалт
    D. Улсын зарцуулалт
    E. Цэвэр экспорт
38. Нийлүүлэлт багасвал .... . (2 оноо)
    A. Үнэ өснө, тоо хэмжээ өснө
    B. Үнэ буурна, тоо хэмжээ буурна
    C. Үнэ буурна, тоо хэмжээ өснө
    D. Үнэ өснө, тоо хэмжээ буурна
    E. Тэнцвэрт үнэ тогтоно
39. Анхнаасаа маш их хөрөнгө оруулалт шаарддаг том үйлдвэрийн хувьд гарц нь маш их байж тухайн салбарын эрэлтийг хангах чадвартай болдог. Энэ нь ямар замаар үүссэн монополь вэ? (2 оноо)
    A. Засгийн газраас олгосон эрхийн улмаас үүссэн монополь
    B. Нэгдэх замаар үүссэн монополь
    C. Онцгой нөөцийг эзэмших замаар үүссэн монополь
    D. Патентийн эрхийн улмаас үүссэн монополь
    E. Төрөлхийн монополь
40. Монголд бараа, үйлчилгээний үнийн эцсийн чөлөөлөлт хэзээ, хэрхэн хийгдсэн бэ? (2 оноо)
    A. 1991 оны 1-р сард Д.Бямбасүрэнгийн засгийн газрын тогтоолоор
    B. 1993 оны 5-р сард П.Жасрайн засгийн газрын шийдвэрээр
    C. 1996 оны намар М.Энхсайханы засгийн газрын шийдвэрээр
    D. 1991 онд УИХ-ын намрын чуулганаар
    E. 1994 онд УИХ-ын намрын чуулганаар
41. Үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний тоо хэмжээ урьдын адил байхад нэмж ажилчин авч ажиллуулснаар хугацаа хэмнэсэн бол … (2 оноо)
    A. Хөдөлмөрийн бүтээмж өснө
    B. Хөдөлмөрийн бүтээмж буурна
    C. Материалын бүтээмж өснө
    D. Материалын бүтээмж буурна
    E. Ашиг нэмэгдэнэ

42. Төв банкнаас хэрэгжүүлдэг мөнгөний бодлогын арга хэрэгслийг зөв тохируулна уу. (3 оноо)

| | |
|---|---|
| 1. Мөнгөний хатуу бодлого | a. Мөнгө зээлийн өсөлт удаан байвал хүүгээ бууруулна |
| 2. Мөнгөний зөөлөн бодлого | b. Арилжааны банкуудын зээл, төлбөрийн эх үүсвэрийн өсөлтийг бууруулна |
| 3. Зах зээлийн нээлттэй ажиллагаа | c. Үнэт цаасыг Засгийн газар, Төв банк худалдан авах, эсвэл зарах ажиллагаа |

A.1c 2b 3a B.1c 2a 3b C.1b 2a 3c D. 1b 2c 3a E. 1a 2b 3c

43. Үүрэн телефоны операторууд 3G болон 3,5G технологийг хүчтэй сурталчилж байгаа нь дараах өгөгдлийн алинтай нь нийцэх вэ? (2 оноо)
A. Борлуулалтын өрсөлдөөн B. Үнийн өрсөлдөөн
C. Технологийн өрсөлдөөн D. Эрэлтийг бий болгох чадварын өрсөлдөөн
E. C болон D-д илүү нийцнэ

44. Аль нь позитив эдийн засгийн асуудал биш вэ? (2 оноо)
A. Шатахууны үнэ одоогийнхоос хямд байх ёстой
B. Цаашид шатахууны үнэ өсөх хандлагатай байна
C. Шатахууны үнэ өссөнөөр өргөн хэрэглээний барааны үнэ нэмэгдэх болно
D. Нэг хүнд ноогдох ДНБ-ий хэмжээ өмнөх жилтэй харьцуулахад өссөн байна
E. Бензиний хямд үнэ нь бензиний их хэрэглээг бий болгодог

45. Аль нэг улс үндэстэн, арьстны хязгаарлагдмал хүрээнд бус угсаа гарвал, яс үндэс, хүйс, арьс өнгө, хил хязгаар ялгаварлахгүйгээр нийтээр шүтэн биширдэг нэг л объекттой байдаг. Энэ нь шүтлэгийн аль хэлбэр вэ? (2 оноо)
A. Монотеизм B. Политеизм C. Анимизм
D. Тотемизм E. Фетишизм

46. Соёлын хоёр талыг судлаад материаллаг бус соёл нь материаллаг соёлоо бодвол удаан хугацаанд өөрчлөгдөнө гэж тайлбарласан эрдэмтэн аль нь вэ? (2 оноо)
A. Ж.Мердок B. О.Шпенглер C. А.Тойнби
D. У.Ф.Огборн E. Г.Гегель

47. Санкцийг дараах өгөгдлийн аль нь хамгийн зөв тодорхойлж байна вэ? (2 оноо)
A. Үл зөрчигдөх тогтоол гэсэн утгатай латин үг
B. Хэм хэмжээг биелүүлэх хэрэгсэл
C. Зан үйлийн стандарт
D. Хэм хэмжээг даган сахиулахын тулд үзүүлж буй нийгмийн шийтгэл ба урамшуулал
E. Хэм хэмжээг биелүүлсний төлөөх урамшуулал

48. … -ын онцгой хэлбэр бол Табу юм. Табу-ямар нэгэн үйлдэл, үг , эд зүйлд тогтоогдсон туйлын хориг юм. (2 оноо)
A. Зан үйл B. Ёс заншил C. Зан заншил
D. Уламжлал E. Зан үйлийн стандарт

49. Онолын хувьд аль бодомж нь буруу вэ? (2 оноо)
A. Уламжлалдаа хүндэтгэлгүй хандвал нийгэм, соёлын хөгжил дэх залгамж шинж алдагдана
B. Уламжлалдаа хүндэтгэлгүй хандвал хүн төрөлхтний үнэт зүйлийн ололт гээгдэхэд хүрнэ
C. Уламжлалыг сохроор дагах нь нийгэмд зогсонги байдал үүсгэнэ
D. Уламжлалыг ухамсартайгаар дагах нь нийгэмд зогсонги байдал үүсгэнэ
E. Уламжлал бол өмнөх үеэсээ бидний өвлөж авсан бүх зүйл юм

50. Эртний Грекийн философич Ксенофон “... Бурхан хүнийг биш, хүн бурхныг өөрийн дүрээр бий болгосон.” гэж тэмдэглэсэн байдаг . Энэ нь ямар үзэл вэ? (2 оноо)
A. Политеизм B. Монотеизм C. Атеизм
D. Теизм E. Индуизм

51. Нийгмийн амьдралд соёлын эзлэх байр суурь, гүйцэтгэх үүргийг тайлбарладаг үзлүүдийг зөв харгалзуулна уу. (3 оноо)

| | |
|---|---|
| 1. Марксист үзэл баримтлал | a. Чухамдаа соёл л нийгмийн амьдралд тодорхойлогч үүргийг гүйцэтгэж, түүний бүхэллэг шинж ба хөгжлийг нөхцөлдүүлж, нийгмийн амьдралын бүх хүрээ, түүн дотроос эдийн засгийн хүрээнд шийдвэрлэгч нөлөө үзүүлдэг хэмээн нотолдог |
| 2. Өрнөдийн нийгэм судлаачдын үзэл баримтлал | b. Нийгмийн амьдралд тодорхойлогч үүргийг материал баялгийн үйлдвэрлэл гүйцэтгэдэг гэж үздэг үзэл |

3. Соёлын гүйцэтгэх үүрэг — c. Соёлын хүмүүжил боловсролын, нэгтгэгч ба салгагч, зохицуулагч гэх мэт

A. 1a 2b 3c  B. 1a 2c 3b  C. 1b 2a 3c  D. 1b 2c 3a  E. 1c 2a 3b

52. TV-9 телевизийн “Хоолондоо” нэвтрүүлгээс янз бүрийн хоол хийх аргачлалын талаар мэдлэг олж авдаг . Энэ нь боловсролын тогтолцооны аль хэлбэрт хамаарах вэ? (2 оноо)
   A. Албан боловсрол
   B. Албан бус боловсрол
   C. Амьдрах орчноос олж авах боловсрол
   D. Гэрийн боловсрол
   E. Мэргэжлийн боловсрол
53. Улс хоорондын харилцааны хэлбэрүүд янз бүр байдгийн дотроос нэлээд давамгайлж ирсэн хэлбэр бол … юм. /Нөхнө үү/ (2 оноо)
   A. Хамтын ажиллагаа
   B. Өрсөлдөөн
   C. Хараат байдал
   D. Дайн
   E. Түншлэл
54. “Энхийн төлөөх түншлэл” хөтөлбөрийг боловсруулан дэлхийн энх тайвны төлөө ажиллах болсон олон улсын байгууллага аль нь вэ? (2 оноо)
   A. АСЕАН
   B. ШХАБ
   C. АПЕК
   D. НАТО
   E. Олон улсын энхийг сахиулах хүчин
55. НҮБ-ын “Асрамжийн зөвлөл” одоогоор ямар үйл ажиллагаа хэрэгжүүлж байгаа вэ? (2 оноо)
   A. Асрамжийн газар нутгийн үйл ажиллагааг хянан явуулах
   B. Асрамжийн системийн аргаар хуучин колони байсан улсуудыг тусгаар тогтнолоо олоход нь чиглүүлэх
   C. Уг зөвлөл үйл ажиллагаагаа түр зогсоогоод байгаа
   D. Шинээр элсэн орсон гишүүн орнуудыг өөрийн ивээлдээ авах
   E. Шинээр тусгаар тогтносон орнуудыг гишүүнээр элсүүлэх
56. Монгол улсын гадаад бодлогын талаар шийдвэр гаргах субъект аль нь вэ? (2 оноо)
   A. УИХ
   B. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл
   C. МУ-ын ерөнхийлөгч
   D. Засгийн газар, гадаад хэргийн сайд
   E. Дээрх бүгд
57. Дэлхийн улс орнууд зайлшгүй харилцах шаардлагад хамаарахгүй нь аль вэ? (2 оноо)
   A. Бусад улстай харилцсанаар өөрийн байр суурийг дэлхийд таниулах
   B. Үндэсний соёл, уламжлалаа хөгжүүлэх
   C. Гадаад орчинтой харилцаж байж зарим хэрэгцээгээ хангаж байдаг
   D. Улс орныхоо аюулгүй байдлыг батлан хамгаалах
   E. Улс орнуудын түүх, соёлыг судлах суралцах боломж нээгддэг

## ХОЁРДУГААР ХЭСЭГ

2.1. Мөнгөний түүхэн хэлбэрүүдийг зөв харгалзуулна уу. (5 оноо)

| | |
|---|---|
| A. Тавааран мөнгө | 1. Эд хөрөнгө барьцаалах үндсэн дээр олгогдох өртгийн тэмдэгт |
| B. Алт мөнгөн зоос | 2. Улсаас тусгайлан гаргасан тодорхой хэмжээний худалдан авах чадвар бүхий түгээмэл хэрэглэдэг мөнгөн тэмдэгт |
| C. Металл зоос | 3. Арилжааны анхны хэлбэр |
| D. Цаасан мөнгө | 4. Гоёл чимэглэлийн хэрэгцээ ихтэй, ховор учраас байнгын эрэлттэй байж нийтээр зөвшөөрөгдсөн мөнгө болон шалгарсан |
| E. Зээлийн мөнгө | 5. Эртний монголчууд Хүннүгийн үеэс хэрэглэж байсан ба нэрлэсэн өртөг нь зоосны металлын өртгөөс давсан, зөвхөн төрөөс баталгаажуулсан үнэтэй мөнгө |

2.2. Ангийн тухай тодорхойлолтуудыг зөв харгалзуулна уу. (5 оноо)

| | |
|---|---|
| A. В.И.Ленины тодорхойлолт | 1. Ангиуд нь эд баялаг, эрх мэдлээр болон нэр хүндээр ялгаатай социал бүлгүүд |
| B. Э.Гидденсийн тодорхойлолт | 2. Ангиудын тэмцэл нь пролетарийн хувьсгалд хүргэх бөгөөд тэгш биш байдал, ялгарлын үндэс болох хувийн өмч устсанаар ангигүй нийгэмд хүрэх үндсэн нөхцөл хангагдана |
| C. Н.Смелзерийн тодорхойлолт | 3. Нийгмийн үйлдвэрлэлийн түүхэн ёсоор бүрэлдсэн нэг тогтолцоонд эзэлж байгаа байр суурь, үйлдвэрлэлийн хэрэгслийг эзэмшиж байгаа байдал, нийгмийн хөдөлмөрийн зохион байгуулалтанд гүйцэтгэж байгаа үүргээрээ ялгаатай хүмүүсийн том том бүлгүүд |
| D. К.Маркс нар | 4. Анги бол хамтын нийгэмлэг биш бөгөөд ангиуд нь хамтын үйлдлийн боломжоот бааз суурийг илэрхийлнэ |

E. М.Вебер — 5. Өөрсдийнх нь амьдралын хэв маягт мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг нийгэм, эдийн засгийн нөөц чадавхиараа ялгаатай хүмүүсийн томоохон бүлэг

2.3. Дараах өгөгдлийн зөв харгалзааг тогтооно уу. (4 оноо)

A. Нийцтэй оролцоо — 1. Төр засаг, түүний байгууллагуудын үйл ажиллагааг сайшааж, зөвтгөдөг
B. Нийцтэй дэмжих оролцоо — 2. Нийгмийн үнэт зүйл, соёл, ёс суртахуун, эрх зүй зэрэг хэм хэмжээнүүдэд харшлаагүй оролцоо
C. Нийцтэй нөлөөлөх оролцоо — 3. Нийтлэг хэм хэмжээ, үнэлэмжид харш оролцоо
D. Нийцгүй оролцоо — 4. Төр засаг, түүний байгууллагуудын үйл ажиллагааг өөрчлөхөд чиглэсэн оролцоо

## ХУВИЛБАР J

## НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

1. Эрдэмтэн Э.Шилзийн тодорхойлсноор, аль нь нийгэм, түүний бүхэллэг, өөрөө хөгжигч, аяндаа цэгцрэх тогтолцоо болон нэгдмэл байдлыг илэрхийлэхгүй вэ? (2 оноо)
   A. Нийгмийн нэгдэл холбоо нь нийгэм хэмээх тэрхүү том тогтолцооны зөвхөн элемент, хэсэг нь мөн
   B. Өрх гэр нь нийгмийн язгуур төлөөллүүдийн илрэл мөн
   C. Нэгдэл холбоо нь өөрийн өмч болох нутаг дэвсгэртэй
   D. Нутаг дэвсгэр нь өөрийн нэр, түүхтэй байна
   E. Нэгдэл холбоо нь тодорхой хувь хүмүүсийн дундаж наслалтаас илүү хугацаанд оршин тогтноно
2. Германы философич О.Шпенглер тухайн нэг иргэншил ямар үе шатуудыг дамждаг гэж үзсэн бэ? (2 оноо)
   A. Үүсэл- Өсөлт-Бууралт- Уналт-Бутрал    B. Залуу нас-Цэцэглэлт- Уналт
   C. Эхлэл-Өрнөлт- Бутрал    D. Залуу нас-Хөгжилт- Бууралт
   E. Үүсэл- Өсөлт- Уналт
3. … гэдэг нь тэгш бус байдлын туйл болсон, хүнийг эрх мэдлээр бүрэн хязгаарласан, хүнийг мөлжих нийгэм, эдийн засаг , хууль зүйн хэлбэр юм. (2 оноо)
   A. Боолчлол    B. Кастын хэв маяг    C. Язгуур угсааны хэв маяг
   D. Хаалттай хэв мая    E. Тэгш бус байдал
4. Нийгмийн социал шилжих хөдөлгөөн нь ямар хоёр гол үзүүлэлтийн тусламжтайгаар өөрчлөгддөг вэ? (2 оноо)
   A. Шилжих хөдөлгөөний эзэлхүүн, цаг хугацаа
   B. Шилжих хөдөлгөөний зай завсар, шилжих хөдөлгөөний эзэлхүүн
   C. Шилжих хөдөлгөөний зай завсар, үе шатны тоон үзүүлэлт
   D. Өөрчлөлтийн хоорондын цаг хугацаа, газар нутаг
   E. Шилжих хөдөлгөөний эзэлхүүн, газар нутгийн хоорондын байрлал
5. Баяр ээжийнхээ багшилдаг сургуулийн 5 дугаар ангид сурдаг. Сургууль дээр шалгалт ирж завгүй байсан тул Баярын ангийн эцэг эхийн хуралд ээж нь оролцсонгүй. Үүрэгтэй холбоотой ямар нөхцөл байдал энд үүсэв? (2 оноо)
   A. Үүргийн мөргөлдөөн    B. Үүргийн тогтолцоо    C. Албан үүрэг
   D. Албан бус үүрэг    E. Үүргийн тасалдал
6. Аль нь уламжлалт нийгмийн шинж вэ? (2 оноо)
   A. Хөдөлмөрийн хуваарь гүнзгий хөгжсөн, мэргэжил нь боловсролтой холбоотой ажлын туршлага дээр тулгуурласан байдаг
   B. Хүмүүсийн хоорондын харилцаа нь үүргийн шинжтэй байдаг
   C. Нийгмийн харилцааг бичигдмэл хууль, гэрээ хэлэлцээр гэх мэт албан ёсны хэм хэмжээгээр зохицуулдаг
   D. Нийгмийн гишүүд нь янз бүрийн нийгмийн бүлэг, давхраа, институтуудын харилцаагаар холбогдсон байна
   E. Хүмүүсийн харилцаа нь ёс заншил, зан үйлд тулгуурласан байдаг
7. Энэтхэгийн ой шугуйгаас хүмүүсийн олсон, чоны тэжээсэн Амала, Камала хэмээх охидын хувь заяа зэрэг нь дараах өгөгдлийн алинд нь хамаарах вэ? (2 оноо)
   A. Фераль хүн    B. Госпитализм
   C. Халамжийн дутагдал    D. Оюуны хоосрол
   E. Хэл сэтгэхүйн доогуур түвшин

8. Нийгмийн хэв маягуудыг зөв харгалзуулна уу. (3 оноо)

| | |
|---|---|
| 1. Аж үйлдвэржихээс өмнөх нийгэм | a. Аж үйлдвэр зонхилох бөгөөд нийгмийн гол зорилго нь мөнгө болж, нийгэмд корпорацууд, бизнесменүүд голлох үүргийг гүйцэтгэдэг нийгэм |
| 2. Аж үйлдвэржсэн | b. Үйлчилгээний хүрээ давамгайлж, нийгмийн гол зорилго нь мэдлэг, мэдээлэл байдаг бөгөөд нийгэмд их сургуулиуд ихээхэн нөлөөтэй байдаг нийгэм |
| 3. Аж үйлдвэржсэний дараах | c. ХАА давамгайлж, нийгмийн гол зорилго нь засаглал байдаг бөгөөд сүм хийд, арми, шашны мяндаг тушаалтнууд голлох үүрэгтэй нийгэм |

A. 1a 2b 3c B. 1a 2c 3b C. 1c 2a 3b
D. 1c 2b 3a E. 1b 2c 3a

9. Дараах үндэслэлүүдээс аль нь “Иргэний нийгэм” гэдэг ойлголтонд хамаарах вэ? (2 оноо)
A. Дэлхий дахины түүхэн глобаль үйл явц
B. Дэлхийн хамтын нийгэмлэгийн удирдлагын байгууллага
C. Нийгмийн нэгдэл холбооны язгуур төлөөллүүдийн илрэл
D. Уг чанартаа эрхэм дээд чин эрмэлзэл бөгөөд үе үеийн дэвшилтэт сэтгэгчдийн буй болгох гэж хүсэж мөрөөдөж ирсэн хийсвэр зүйл
E. Нийгмийн тодорхой багц харилцаануудын цогц, дэд тогтолцоо

10. Гэр бүлийн засаглалын тогтолцоонд эх юмуу эхнэр голлох ёсыг юу гэж нэрлэдэг вэ? (2 оноо)
A. Полигени B. Матриархаль C. Матрилокаль
D. Эндогами E. Патрилокаль

11. Мэдээлэл цуглуулахын тулд судалж байгаа хамт олонтой тодорхой хугацаанд хамт ажиллав. Энд судалгааны ямар арга голчлон хэрэглэгдэх вэ? (2 оноо)
A. Анкетын арга B. Түүврийн арга C. Ажиглалтын арга
D. Индукцийн арга E. Дедукцийн арга

12. Оросын нийгэм судлаач С.И.Самыгин нар хүний нийгэмшлийг 5 үе шатанд хуваан авч үзжээ. Нийгэмд эзлэх байр сууриа эрж хайх эрмэлзлийн үе аль шатанд нь хамаарах вэ? (2 оноо)
A. Дасан зохицлын шат B. Бодгальжих шат C. Интеграцийн шат
D. Хөдөлмөрийн шат E. Хөдөлмөрийн дараах шат

13. Хөдөлмөрийн хуваарь бол нийгмийн өсөн нэмэгдэж буй ээдрээтэй байдлын шалтгаан, үр дагавар болдог гэсэн үндэслэлийг хэн гаргасан бэ? (2 оноо)
A. Т.Парсонс B. Г.Спенсер C. Дюркгейм
D. Ф.Тённис E. Р.Мертон

14. Монгол улсын Үндсэн хуульд зааснаар шүүх ямар үүрэгтэй байгууллага вэ? (2 оноо)
A. Иргэдээр хуулийг сахиулах B. Шударга ёсыг хангах
C. Аливаа зөрчил маргааныг хянан шийдвэрлэх D. Мөрдөн байцаах
E. A, B, C хариулт зөв

15. Засгийн эрх мэдэл эзэмшигч, идэвхтэн, эрх баригч элит, лидер, хувь хүн, нийгмийн нийтлэг болох ард түмэн, үндэстэн, анги, давхраа болон төр, нам, сонирхлын бүлэг зэрэг нийгмийн институт нь … юм. (2 оноо)
A. Засаглалын объект B. Засаглалын субъект C. Засаглалын нөөц
D. Засаглалын механизм E. Засаглалын хэлбэр

16. Төрийн шүүх байгууллагыг нэрлэнэ үү. (2 оноо)
A. Парламент B. Яамд C. Прокурор
D. Засгийн газар E. Төр

17. … нь нийгмийн хурцадмал, тогтворгүй байдлыг арилгах гол механизмын үүргийг гүйцэтгэдгээрээ онцлогтой. (2 оноо)
A. Дэмжлэг B. Шаардлага C. Шийдвэр-үйлдэл
D. Гаралт E. Эргэх холбоо

18. Ардчилсан бус дэглэмийн гол шинж аль нь вэ? (2 оноо)
A. Өмчийн олон хэлбэр
B. Улс төрийн плюрализм
C. Улс төрийн болон иргэний соёлд төр тулгуурлах
D. Хүний эрхийг баталгаажуулахад төрийн үзэл суртлыг чиглүүлэх
E. Хүний эрх, эрх чөлөөг нэг үзэл сурталд захируулах

19. Төрийг ангилах анхны оролдлогыг Платон, Аристотель нар хийсэн байдаг. Тэд ямар шалгуурыг үндэс болгон төрийг ангилсан байдаг вэ? (2 оноо)
    A. Эрх мэдлийг хэн хэрэгжүүлж буйг үндэс болгосон
    B. Өөрчлөлт хөгжилтийн онцлогийг үечлэн тодорхойлох ерөнхий хандлагад тулгуурласан
    C. Материаллаг үйлдвэрлэлийн хөгжлийн үе шатанд тулгуурласан
    D. Иргэншлийн онол, арга зүйг үндэслэн
    E. Төрөөс эрх мэдлээ хэрэгжүүлэх аргаар нь
20. Намыг хэрхэн тодорхойлж болох вэ? (2 оноо)
    A. Намууд өөрийн гишүүн гэдгээр халхавчилж шударга ял шийтгэлээс бултуулдаг
    B. Нам нь төрийн албан тушаалыг шан харамж маягаар хуваарилдаг
    C. Нам нь төрийн институтэд үл итгэх байдлаар ханддаг
    D. Сонгуулийн үр дүнд нэр дэвшигчийг төрийн байгууллагад суулгах чадвартай улс төрийн бүлэг
    E. Улс төрийн шийдвэрийг дэмжсэн буюу эсэргүүцсэн ухуулга сурталчилгааны компанийг зохион байгуулдаг бүлэг
21. Францын гүн ухаантан Жан Боден төрийн бүрэн эрхийг хууль тогтоох, үл хуваагдах ба саадгүй эрх мэдэл гэж тодорхойлсон нь бий. Доорх өгөгдлийн аль нь Ж.Бодены зорилгод хамаарах вэ? (2 оноо)
    A. Францад хаант засгийн эрх дархыг хамгаалахад чиглэж байсан
    B. Францын хаант засгийг унагаахад чиглэж байсан
    C. Парламентат засаглалыг бий болгох зорилготой байсан
    D. Нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэглэгдэх хууль гаргаж хэрэгжүүлэх
    E. Үндэсний парламентаас дээгүүр ажиллаж чадах олон улсын байгууллага байгуулах
22. Дараах газруудын алинд нь сонгуулийн сурталчилгаа явуулахыг хориглодог вэ? (2 оноо)
    A. Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага
    B. Сонгуулийн хороод
    C. Хүмүүнлэгийн байгууллага
    D. Буяны болон шашны байгууллага
    E. Дээрх бүгд
23. Монгол улсын үндсэн хуулийн 16-р зүйлийн 5-д, "... Өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах,хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд мөнгөний тусламж авах эрхтэй" гэж заасан нь .... баталгаа юм. (2 оноо)
    A. Манай төр социал төрийн баримжаатай гэдгийн
    B. Манай төр эрхзүйт төрийн баримжаатай гэдгийн
    C. Хүмүүсийн байгалиас заяасан тэгш бус байдлыг засч залруулах
    D. Эдийн засгийн либерализм зах зээлийн зохицуулалтад давуу байдал олгодгийн
    E. Төр, иргэний нийгэм хоёр эрхзүйт хуулийн үндсэн дээр тэнцвэртэй орших
24. Ямар шалтгааны улмаас хүмүүс хүний эрхийн төлөө, байгаль орчныг хамгаалахын төлөө, хээл хахууль, нийгмийн шударга бус байдлын эсрэг тэмцэж буй бүлгүүдэд нэгдэж ордог вэ? (2 оноо)
    A. Материаллаг ашиг тусын тулд
    B. Сэтгэл зүйн ашиг тусын тулд
    C. Чөлөөт цагаа өнгөрүүлэхийн тулд
    D. Нийгмийн байр сууриа өөрчлөх
    E. Хүсэл тэмүүллээ гүйцэлдүүлэхийн тулд
25. Монгол улсад 1990 онд болсон Улсын бага хурлын сонгуулийг ямар тогтолцоогоор явуулсан бэ?
    A. Мажоритар
    B. Холимог
    C. Пропорциональ
    D. Аль аль нь зөв
    E. Аль нь ч биш
26. Эрх зүйт болон социал төрийн зарчим, үзэл санаа өөр өөр ч адил тал бас бий. Аль өгөгдөл нь адил талыг илэрхийлэх вэ? (2 оноо)
    A. Хоёулаа хувь хүний сайн сайхан байдлыг хангах зорилгод үйлчилнэ
    B. Аль аль нь ардчилсан төрийн тогтолцооны хэв маяг
    C. Онолын үндэс нь социал демократ
    D. Дээрх бүгд адил талыг илэрхийлнэ
    E. Зөвхөн A, B нь адил талыг илэрхийлнэ
27. Улс төрийн соёлын ангиллыг зөв харгалзуулаарай. (3 оноо)
    1. Улс төрийн соёлыг хэрэгжих хүрээгээр нь — a. Нам, эвсэл холбоодын
    2. Улс төрийн соёлыг түвшингээр нь — b. Оролцогчдын буюу идэвхтэй, хамжлагын буюу албадлагын гэх мэт
    3. Улс төрийн соёлыг хөгжлийн байдлаар нь — c. Танин мэдэх, сэтгэл хөдлөлийн, үнэлэх
    A. 1a 2b 3c
    B. 1c 2b 3a
    C. 1a 2c 3b
    D. 1c 2a 3b
    E. 1b 2c 3a

28. Улс төрийн системийн төлөвшилд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйл нь юу вэ? (2 оноо)
    A. Харь соёлын үнэт зүйлсийг өөрийн шүүлтүүрээр тунгаан авч үзэх
    B. Нөөцийн дахин хуваарилалт олигархуудын үзэмжээр шийдэгдэж буй явдал
    C. Монголын улс төрийн соёл улам олон талт, нийгэм баялаг агуулгатай болж, шинэчлэгдсэн байх
    D. Засаглалын холбоо бүхий харилцаануудын зохион байгуулалтын хэлбэрүүд
    E. Янз бүрийн ашиг сонирхлыг илэрхийлдэг парламентын хэлбэрүүд
29. Нийгмийн баялгийн тодорхой хэсгийг шударгаар олж авч өөрийн болгон түүнийгээ мэдэж захиран зарцуулах туйлын эрх эдлэх нь дараах өгөгдлүүдийн алинд нь тохирох вэ? (2 оноо)
    A. Өмч B. Нийтийн өмч C. Төрийн өмч
    D. Хувийн өмч E. Өмч хувьчлал
30. … гэдэг нь үйлдвэрлэлийн боломжийг бүрэн дүүрэн хүчин чадалд нь хүргэж ашиглах явдлыг илэрхийлдэг үзүүлэлт юм. (2 оноо)
    A. Үр ашиг B. Ашиг C. Нийт бүтээмж
    D. Хөдөлмөрийн бүтээмж E. Нийт орлого
31. Парламентаас баталж засгийн газар бүрдүүлэн зарцуулдаг мөнгөн хөрөнгийг .......... гэнэ. (2 оноо)
    A. Төсвийн гадуурх улсын сангууд B. Улсын төсөв
    C. Хүн амын санхүү D. Орон нутгийн төсөв
    E. Байгууллагын төсөв
32. Үйлдвэрлэлийн уламжилсан хүчин зүйл аль нь вэ? (2 оноо)
    A. Газар B. Хөдөлмөр
    C. Капитал D. Үйлдвэрлэл эрхлэх ур чадвар
    E. A, B, C хариулт
33. Аль нь уламжлалт эдийн засгийн тогтолцооны шинж биш вэ? (2 оноо)
    A. Шашин анхдагч байдалтай
    B. Техникийн дэвшил, хөрөнгө оруулалт хийх явдал хязгаарлагдмал
    C. Үйлдвэрийн газар нь улсын даалгавар биелүүлэх гол үүрэгтэй
    D. Эдийн засагт хувь хүний үүрэг оролцоо ихтэй
    E. Нийгэм эдийн засгийн зогсонги байдал ноёлдог
34. Санхүүгийн банкны үүрэг аль нь вэ? (2 оноо)
    A. Эдийн засаг дахь мөнгөний хэмжээг зохицуулах
    B. Мөнгөний тогтворт байдлыг хангах
    C. Хөрөнгө оруулагч болон компаниудаас их хэмжээний мөнгөн хадгаламж хүлээн авах
    D. Мөнгөн хадгаламж хүлээж авах, зээллэг өгөх, олон улсын худалдаа арилжааг санхүүжүүлэх
    E. Дээрх бүгд
35. Мөнгөний бодлого гэж юу вэ? (2 оноо)
    A. Мөнгөний нийлүүлэлт
    B. Эдийн засаг дахь мөнгөний нийт тоонд болон тэдгээрийг тавьж олгох өртөгт нөлөөлөх
    C. Гүйлгээнд мөнгийг гаргах, гүйлгээнд байгаа илүүдэл мөнгийг татан авах
    D. Арилжааны банкны зээл олгох хэмжээг төв банкнаас зохицуулах үйл явц
    E. Банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулах
36. “Мобиком”, “Скайтел” компаниуд байнгын хэрэглэгчидтэй болохын тулд хямд үнэтэй, чанартай үйлчилгээ нэвтрүүлэхээр өрсөлдөж байгаа нь өрсөлдөөний аль хэлбэрт хамаарах вэ? (2 оноо)
    A. Борлуулалтын өрсөлдөөн B. Үнийн өрсөлдөөн
    C. Технологийн өрсөлдөөн D. Эрэлтийг бий болгох чадварын өрсөлдөөн
    E. Зар сурталчилгаагаар өрсөлдөх
37. ҮНБ-ийг орлогоор тооцохдоо дараах хариултын алийг нь харгалзахгүй вэ? (2 оноо)
    A. Цалин хөлс B. Түрээс C. Зээлийн хүү
    D. Хэрэглээ E. Ашиг
38. “Өгөөж” ХХК бүтээгдэхүүнээ хорооллын дэлгүүрүүдэд үйлдвэрийнхээ үнээр нийлүүлдэг гэвэл тухайн дэлгүүрүүдийн хувьд бараагаа ямар үнээр зарж борлуулах вэ? (2 оноо)
    A. Үйлдвэрийн үнээр B. Бөөний үнээр C. Жижиглэнгийн үнээр
    D. Нэрлэсэн үнээр E. Биржийн үнээр
39. Ахиу орлогыг хэрхэн тодорхойлох вэ? (2 оноо)
    A. Бүтээгдэхүүний үнэ, борлосон бүтээгдэхүүний хэмжээгээр илэрхийлэгдэнэ
    B. Гарцын борлуулалт нэг нэгжээр өөрчлөгдөхөд нийт орлогод гарах өөрчлөлтөөр хэмжигдэнэ
    C. Гарцын борлуулалтыг нийт орлогод харьцуулна
    D. Борлогдсон бүтээгдэхүүний хэмжээг бүтээгдэхүүний үнэд харьцуулна
    E. Нийт орлого, зарлагын зөрүү

40. Хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэхийн тулд .... хэрэгтэй. (2 оноо)
   A. Нэгж хугацаанд үйлдвэрлэх бүтээгдэхүүний тоог нэмэгдүүлэх
   B. Хүмүүсийг олноор ажиллуулах
   C. Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх хугацааг богиносгох
   D. Үйлдвэрлэлийнхээ хүрээг тэлэх
   E. А ба С хариулт зөв

41. Мөнгө зээлийн өсөлт удаан байвал хүүгээ бууруулна. Энэ үед ямар сөрөг үр дагавар гарч болох вэ? (2 оноо)
   A. Бодит хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл нэмэгдэнэ
   B. ҮНБ-ий хэмжээ буурна
   C. Инфляци өсөх магадлалтай
   D. Инфляци буурах магадлалтай
   E. Дефляци үүсэх хандлагатай

42. Зээл, түүний хэлбэрийг зөв тохируулаарай. (3 оноо)

| | |
|---|---|
| 1. Наймааны зээл | a. Зээлээс олох орлогын жилийн нийт хэмжээг зээлийн нийт дүнд харьцуулна |
| 2. Банкны зээл | b. Аж үйлдвэрийн капиталын орчилтой холбоотой, түүнээс уламжлан гардаг |
| 3. Хүүгийн норм | c. Ашиглагдаагүй, сул чөлөөтэй мөнгөн хөрөнгийг арилжаанд оруулах, мөнгөөр зээл олгох |

   A. 1c 2b 3a  B. 1b 2c 3a  C. 1c 2a 3b  D. 1b 2a 3c  E. 1a 2b 3c

43. Барилгын компани барьж буй объектоо хугацаанд нь ашиглалтанд өгөхийн тулд ажилчид нэмж авснаар зорилгодоо хүрч чадав. Ингэснээр … (2 оноо)
   A. Хөдөлмөрийн бүтээмж өссөн
   B. Хөдөлмөрийн бүтээмж буурсан
   C. Материалын бүтээмж өссөн
   D. Материалын бүтээмж буурсан
   E. Бүтээмжийн өөрчлөлт гараагүй

44. Норматив эдийн засгийн асуудал аль нь вэ? (2 оноо)
   A. Шатахууны үнэ одоогийнхоос хямд байх ёстой
   B. Цаашид шатахууны үнэ өсөх хандлагатай байна
   C. Шатахууны үнэ өссөнөөр өргөн хэрэглээний барааны үнэ нэмэгдэх болно
   D. Нэг хүнд ноогдох ДНБ-ий хэмжээ өмнөх жилтэй харьцуулахад өссөн байна
   E. Дээрх бүгд

45. Анх соёлын түгээмэл зүйлсийн үзэл баримтлалыг боловсруулах оролдлого хийж, үүнд хөдөлмөрийн багаж зэвсэг бүтээх, хоол хүнс бэлтгэх, хамтын хөдөлмөр гэх мэт олон нийтлэгийг багтаасан 60 гаруй соёлын түгээмэл шинжийг ангилан авч үзсэн социологич аль нь вэ? (2 оноо)
   A. Ж.Мердок  B. О.Шпенглер  C. А.Тойнби
   D. У.Ф.Огборн  E. Г.Гегель

46. Хэм хэмжээг даган сахиулахын тулд үзүүлж буй нийгмийн шийтгэл болон урамшууллыг … гэнэ. (2 оноо)
   A. Хариуцлага  B. Санкци
   C. Нийгмийн хяналт  D. Нийгмийн дэг журам
   E. Дэг журам сахиулах үйл явц

47. Хэлний нийгмийн үүргийг тоочихдоо буруу зүйл оруулсан бол аль нь вэ? (2 оноо)
   A. Соёлыг нэг үеэс нөгөө үед дамжуулах
   B. Соёлыг бүтээх, илгээх
   C. Хүмүүс хоорондоо мэдээлэл солилцох
   D. Сэтгэл хөдлөлөө илэрхийлэх
   E. Хэм хэмжээ тогтоох

48. Олон оронд гудамжаар нүцгэн явах, ахмад хүнийг доромжлох, эмэгтэй хүнийг зодох, сул дорой хүмүүсийг гомдоох, тахир дутуу хүмүүсийг даажигнах гэх мэтийн үйлдлийг ёс суртахуунгүй хэмээн үздэг. Энэ нь дараах ойлголтын алинд нь хамаарах вэ? (2 оноо)
   A. Зан үйл  B. Ёс заншил  C. Зан заншил
   D. Уламжлал  E. Зан үйлийн стандарт

49. Онолын хувьд аль бодомж нь буруу вэ? (2 оноо)
   A. Уламжлалдаа хүндэтгэлгүй хандвал нийгэм, соёлын хөгжил дэх залгамж шинж алдагдана
   B. Уламжлалдаа хүндэтгэлгүй хандвал хүн төрөлхтний үнэт зүйлийн ололт гээгдэхэд хүрнэ
   C. Уламжлалыг сохроор дагах нь нийгэмд зогсонги байдал үүсгэнэ
   D. Уламжлалыг ухамсартайгаар дагах нь нийгэмд зогсонги байдал үүсгэнэ
   E. Уламжлал бол өмнөх үеэсээ бидний өвлөж авсан бүх зүйл юм

50. Наадмаар гадаадын жуулчид Монголд олноор ирдэг нь дараах өгөгдлийн алинаар тайлбарлагдах вэ? (2 оноо)
   A. Соёл универсал шинжтэй
   B. Бүх хүнд адилхан хэрэгцээ байдаг
   C. Соёлын холбоо
   D. Соёлын олон талт байдал
   E. Үндэсний соёлын онцлогийг сурталчлах өргөн боломж

51. Нийгмийн амьдралд соёлын гүйцэтгэх үүргийг зөв тохируулаарай. (3 оноо)

| | |
|---|---|
| 1. Хүмүүжил-боловсролын үүрэг | a. Соёлыг эзэмшсэнээр хүмүүст аль нэг үндэстэн, ард түмэн, шашин, бүлэгт харъяалагдсанаа ухаарах мэдрэмж төрдөг |
| 2. Нэгтгэгч-салгагч үүрэг | b. Зан төрхийг төлөвшүүлэх бөгөөд ер нь соёл бол хүн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх хүрээ болдог |
| 3. Зохицуулагч үүрэг | c. Хүнийг хүн болгодог |

A.1c 2a 3b B. 1c 2b 3a C.1a 2b 3c D. 1a 2c 3b E. 1b 2c 3a

52. Болд гэрээсээ гарч яваад хэтэвчтэй мөнгө олов. 100.000 төгрөг байснаас хагасыг нь үржээ. Орой иртэл ах нь хэтэвчээ гээсэн тухай ярьж байв. Болд мөнгийг нь үрсэн тул айгаад юу ч хэлсэнгүй. Болд ямар нэг хэм хэмжээ зөрчсөн үү? (2 оноо)

A. Эрхийн хэм хэмжээг зөрчсөн B. Шашны ёсыг гажуудуулсан
C. Ёс суртахууны хэм хэмжээг илүү зөрчсөн D. Улс төрийн хэмжээ зөрчсөн
E. Хэм хэмжээ зөрчөөгүй

53. Гадаад бодлогын хэрэгжилтэнд тавьсан зорилтуудыг биелүүлэхэд ашиглах хэрэгслийг хэрхэн ангилдаг вэ? (2 оноо)

A. Мэдээлэл, суртал нэвтрүүлгийн, улс төрийн, эдийн засгийн
B. Мэдээлэл суртал нэвтрүүлгийн, улс төрийн, эдийн засгийн, цэргийн
C. Суртал нэвтрүүлгийн, улс төрийн, эдийн засгийн, соёлын
D. Цэргийн, суртал нэвтрүүлгийн, улс төрийн, эдийн засгийн, соёлын
E. Улс төрийн, эдийн засгийн, соёлын

54. Төв Азийн бүс нутаг дахь олон улсын терроризм, шашны экстремизм, үндэсний салан тусгаарлах үзлийн эсрэг улс орнуудын хүчийг нэгтгэх, мөн харилцан итгэлцэл, найрсаг харилцааг бэхжүүлэх, улс төр, эдийн засаг, соёл, шинжлэх ухаан, техник, технологи, экологийн салбарт хамтын ажиллагааг өргөжүүлэх, тухайн бүс нутагт аюулгүй тогтвортой байдлыг хангах зорилготой байгууллага аль нь вэ?

A. АСЕАН B. ШХАБ C. АПЕК D. НАТО E. АСЕМ

55. НҮБ-ын Энхийг сахиулах үйл ажиллагаа нь юунаас эхэлсэн бэ? (2 оноо)

A. Хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрийн эсрэг уриалга гаргаснаар
B. Хилийн маргаантай асуудлыг зохицуулах ажиллагаанаас
C. Гал зогсоох ажиллагаанаас
D. Өлсгөлөн, ядуурлыг бууруулах ажиллагаанаас
E. Тусламжийн барааг ядуу орнуудад түгээх ажлаас

56. Монгол Улсын гадаад бодлогын зорилтод аль нь нийцэхгүй вэ? (2 оноо)

A. Хүн төрөлхтний хөгжлийн жамыг даган бүх улс оронтой найрсаг харилцаатай байх
B. Олон улсын хамтын нийгэмлэгт байр сууриа бэхжүүлэх
C. Улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бат найдвартай хангах
D. Улс төр, эдийн засаг болон бусад ашиг сонирхлын шүтэлцээ бүхий харилцаа хөгжүүлэх
E. Социализмын эрх ашгийг өмгөөлөн хамгаалах

57. Монгол, Японы харилцаа, хамтын ажиллагаа бүхий л салбарт өргөн хүрээг хамарч “Иж бүрэн түншлэл”-ийн дагуу хөгжиж байна. Энэ харилцаа нь Монгол Улсын гадаад улс төрийн бодлогын аль чиглэлд хамаарах вэ? (2 оноо)

A. Хөрш орнуудтай найрсаг, тэнцвэртэй, хамтын ажиллагааг хөгжүүлэх
B. Өрнө, Дорнын өндөр хөгжилтэй гүрнүүдтэй хамтын ажиллагааг хөгжүүлэх
C. Азийн бүс нутагт байр сууриа бататгах
D. НҮБ болон түүний төрөлжсөн байгууллагуудтай хамтран ажиллах
E. Социалист хамтын нөхөрлөлийн гэгдэж байсан улсуудтай найрсаг харилцааг хөгжүүлэх

## ХОЁРДУГААР ХЭСЭГ

2.1. Өгөгдлийг зөв харгалзуулаарай. (5 оноо)

| | |
|---|---|
| A. Цалин хөлс | 1. Төрийн өмчийг ашиглуулсны төлөө иргэн, байгууллагаас авч улс, орон нутгийн төсөвт болон тусгай санд төвлөрүүлж байгаа мөнгөн хөрөнгө |
| B. Нэрлэсэн цалин | 2. Хууль тогтоомжийн дагуу хуулийн этгээдүүд болон иргэдээс авч байгаа төрийн хураамж |
| C. Бодит цалин | 3. Хүний хөдөлмөрийг ашигласны төлөө түүний тоо чанарт нийцүүлэн төлөх мөнгөн төлбөр |

| | |
|---|---|
| D. Татвар | 4. Ажилтан хөдөлмөрийнхөө үр дүнд авсан мөнгөөр хэчнээн хэмжээний бараа, үйлчилгээ худалдан авч чадахыг харуулдаг |
| E. Төлбөр | 5. Ажилтан цаг, өдөр, сар гэх мэт тодорхой хугацаанд зарцуулсан хөдөлмөрийнхөө төлөө авч буй мөнгөн төлбөрийн дүн |

2.2. Давхраажлын дараах хэв маягуудыг зөв харгалзуулна уу. (5 оноо)

| | |
|---|---|
| A. Гарвалын | 1. Нас хүйс, хүч чадал, гоо үзэмж зэргээс үүдэлтэй |
| B. Этакрат | 2. Биеийн болон оюуны хөдөлмөрт хандах хандлага гэх зэрэг нэр хүнд, хүндэтгэлийн ялгаанаас гардаг |
| C. Нийгэм-мэргэжлийн | 3. Шатлан захирах ёс, зэрэг дэвийн хуваарь, цэргийн дүрэм, төрийн байгууллагын зэрэглэл, хууль ёсоор баталгаажуулсан хүнд сурталт нийгмийн давхраажил |
| D. Соёл-билэгдлийн | 4. Нийгмийн ач холбогдолтой мэдээлэл олж авах, ашиглах ялгаанаас гардаг |
| E. Соёл-хэм хэмжээний | 5. Тухайн ажил хөдөлмөр, мэргэжлийг эрхлэх батламжлал, мэргэшсэн байдлаас хамаардаг |

2.3. Өгөгдлийг зөв харгалзуулна уу. (4 оноо)

| | |
|---|---|
| A. Улс төрийн хүлээцэт байдал | 1. Бүх хүнийг ижил боломжтой байлгаж, арьс өнгө, шашин шүтлэг, үндэс угсаа, хүйсээр ялгаварлахгүй |
| B. Иргэдийн оролцоо | 2. Ард түмний олонх улс орныг удирдаж байхад цөөнхийн эрхийг хамгаалсан байх ёстой |
| C. Тэгш эрх | 3. Иргэд өөрсдийнхөө талаар шийдвэр гаргахад идэвхтэй үйл ажиллагаа явуулах, бие даасан байр суурь баримтлах |
| D. Чөлөөт шударга сонгууль | 4. Төр засагт өөрсдийгөө төлөөлөх албан тушаалтныг ажиллуулах, солих |

## 2009 оны Нийгмийн тухай мэдлэг хичээлийн даалгаврын түлхүүр

| Нэгдүгээр хэсэг | | | | | |
|---|---|---|---|---|---|
| № | Хувилбар B | Хувилбар D | Хувилбар F | Хувилбар H | Хувилбар J |
| 1 | D | A | B | A | A |
| 2 | A | B | C | D | B |
| 3 | A | E | C | B | A |
| 4 | C | D | A | A | B |
| 5 | A | E | D | A | E |
| 6 | C | C | D | E | E |
| 7 | B | D | E | A | A |
| 8 | A | D | B | C | C |
| 9 | B | B | B | A | D |
| 10 | B | B | C | C | B |
| 11 | B | C | B | C | C |
| 12 | D | B | D | E | C |
| 13 | E | A | C | B | C |
| 14 | E | B | C | A | E |
| 15 | D | C | D | A | B |
| 16 | D | B | A | C | C |
| 17 | B | C | C | B | E |
| 18 | D | A | B | D | E |
| 19 | E | A | E | A | A |
| 20 | D | E | B | B | D |
| 21 | D | A | D | B | A |
| 22 | D | E | B | B | E |
| 23 | C | B | A | E | A |
| 24 | A | E | B | A | E |
| 25 | C | B | E | A | C |
| 26 | E | E | B | B | E |
| 27 | E | A | C | E | C |
| 28 | D | E | E | D | B |
| 29 | B | C | D | D | D |
| 30 | C | A | B | B | A |
| 31 | E | E | C | B | B |
| 32 | D | B | D | D | C |
| 33 | A | C | E | E | C |
| 34 | E | D | C | C | D |
| 35 | B | E | E | E | B |
| 36 | C | E | D | C | B |
| 37 | B | B | C | A | D |
| 38 | B | B | C | D | B |
| 39 | D | A | A | E | B |
| 40 | B | E | C | C | E |
| 41 | E | A | D | A | C |
| 42 | A | B | B | C | B |
| 43 | D | C | E | E | A |
| 44 | E | E | D | A | A |
| 45 | D | C | D | A | A |
| 46 | B | E | B | D | B |
| 47 | E | A | C | D | E |

| № | Хувилбар B | Хувилбар D | Хувилбар F | Хувилбар H | Хувилбар J |
|---|---|---|---|---|---|
| 48 | A | B | E | B | B |
| 49 | D | E | B | D | D |
| 50 | A | B | C | C | C |
| 51 | B | B | D | C | A |
| 52 | C | C | C | C | C |
| 53 | A | B | C | B | B |
| 54 | A | B | D | D | B |
| 55 | E | C | E | C | C |
| 56 | C | A | D | E | E |
| 57 | C | C | C | B | B |

| Хоёрдугаар хэсэг | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Хувилбар B | | | Хувилбар D | | | Хувилбар F | | | Хувилбар H | | | Хувилбар J | | |
| | 2.1 | 2.2 | 2.3 | 2.1 | 2.2 | 2.3 | 2.1 | 2.2 | 2.3 | 2.1 | 2.2 | 2.3 | 2.1 | 2.2 | 2.3 |
| a | 4 | 2 | 2 | 3 | 2 | 2 | 4 | 3 | 1 | 3 | 3 | 2 | 3 | 1 | 2 |
| b | 5 | 4 | 1 | 4 | 1 | 1 | 3 | 1 | 2 | 4 | 5 | 1 | 5 | 3 | 4 |
| c | 1 | 1 | 4 | 5 | 4 | 4 | 1 | 4 | 4 | 5 | 1 | 4 | 4 | 5 | 1 |
| d | 3 | 5 | 3 | 1 | 5 | 3 | 2 | 2 | 3 | 2 | 2 | 3 | 2 | 4 | 5 |
| e | 2 | 3 | | 2 | 3 | | 5 | 5 | | 1 | 4 | | 1 | 2 | |
| f | | | | | | | | | | | | | | | |